

МОДУЛЬ

1

**ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ БА
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО**



Модуль 1

ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ БА ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар боловсруулсан: Др. Адилбишийн Батхишиг (PhD)

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Баяндалайн Баярмаа
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй НҮБ-ын "Итгэлцлийн Сан"-гийн санхүүжилттэй "Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь" төслийн хүрээнд боловсруулж, хэвлүүлэв.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол Улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org | Модулийг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс 2023 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.	7
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	8
НЭГ. ХҮҮХДИЙН ЭРХ БА ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА.	11
1.1. Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлагын үндсэн ойлголт	12
1.2. Хүүхдийн эрх, эрхэд суурилсан аргачлалын ач холбогдол	17
1.3. Хүүхдийн эрх, эрхэд суурилсан онол, арга зүй	18
1.4. Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлагын хэрэглээ, сайн туршлага	21
ХОЁР. ХҮҮХДИЙН ХАМГААЛАГДАХ ЭРХ	23
2.1. Хүүхдийн хамгаалагдах эрх, түүний үндсэн ойлголт	24
2.2. Хүүхдийн хамгаалагдах эрх түүний ач холбогдол	27
2.3. Хүүхдийн хамгаалагдах эрх, түүний үндэслэл	28
2.4. Хүүхдийн хамгаалагдах эрхийг хэрэгжүүлэх арга зүй, аргачлал	30
2.5. Хүүхдийн хамгаалагдах эрхийн талаар бусад улс орны сайн туршлага	35
ГУРАВ. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД	37
3.1. Хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжүүлэх арга замын талаарх ойлголт.	38
3.2. Сэдвийн ач холбогдол.	41
3.3. Онолын үндэслэл	42
3.4. Хүүхэд хамгааллын бодлогын бусад улс орны сайн туршлага.	45
НОМ ЗҮЙ.	47

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хүндэтгэн хангах, хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын, бие даасан, хараат бус иргэний нийгмийн байгууллага юм. ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь НҮБ-ын Итгэлцлийн Сан (UN Trust Fund)-гийн санхүүжилтээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг гурван жилийн (2021-2024) хугацаатай, нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын хороодын дүгнэлт зөвлөмжүүдэд охин хүүхдийг бэлгийн болон бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалж, хүчирхийллийн аливаа хэлбэрээс охидыг хамгаалах, нэр төрийг нь хүндэтгэхийг эрхэмлэх ёстойг онцлон тэмдэглэдэг. Монгол Улсад хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа хэдий ч жендэрт суурилсан хүчирхийлэл, охидын эсрэг хүчирхийллийн тоо буурахгүй хэвээр байгаад зовниж, Хүүхдийг Ивээх Сан охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилго тавин ажиллаж байна.

Төслийн хүрээнд бид хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх зорилго бүхий 11 модулиас бүрдэх багц гарын авлагыг боловсруулан та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Тус гарын авлага нь хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын тогтолцоо, салбарын ажилтнуудын оролцоо, үүрэг, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй (хохирогч/даван туулагчид ээлтэй) арга зүй, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ, кейс менежмент, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охидод үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, хүүхэд хамгааллын ажилтнуудын ажлаас халшрах хам шинжийн талаарх ойлголтыг өгч, хүүхдэд сэтгэцийн дам гэмтэл учруулахгүйгээр, цаг алдахгүй мэргэжлийн үйлчилгээг чанартай үзүүлэх үр чадварыг өсгөх зорилготой юм.

Олны хүч оломгүй далай гэдэг ээ.

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох, эрхээ ялгаварлалгүй эдэлдэг, хариуцлагатай нийгмийг цогцлоох үйлст хувь нэмрээ оруулж, сургалтын энэхүү багцын “Модуль 1. Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого” хэсэгт гэрээлэн ажилласан Др. Адилбишийн Батхишигт болон Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багтаа талархал илэрхийлье.

Энэ чиглэлээр бидний нэгэн адил хувь нэмэр оруулж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байгаа зорилго нэгт, хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түншүүддээ талархал илэрхийлье.

Энхбатын Цолмон

ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

Багц гарын авлагын 11 модуль тус бүрийн хоорондын уялдаа холбоо, зорилгыг доорх хүснэгтэд харууллаа.

Модулийн нэр	Зорилго
Модуль 1 Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого	Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлага, хүүхдийн хамгаалагдах эрх, хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, бодлогын талаар онол, практик хэрэглээ, сайн туршлагыг танилцуулах
Модуль 2 Хүүхэд хамгааллын үйлчилгээ ба кейс менежмент	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх гэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин тус бүрд хамгааллын үйлчилгээ хүргэх, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээг хэрхэн хүргэх
Модуль 3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байрны үйлчилгээ	Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байранд байрлаж буй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нас, сэтгэцийн онцлогт тохирсон үйлчилгээг хэрхэн үзүүлэх, үйлчилгээг стандартын дагуу сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй байдлаар үзүүлэхэд анхаарах асуудал, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд анхан шатны болон хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх
Модуль 4 Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ	Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ, үйлчилгээнд хамруулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын үнэлгээний талаар үндсэн ойлголттой болж, хувилбарт үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний төлөвлөлт хийхэд баримтлах зарчим, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулах
Модуль 5 Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн давуу талд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэр дундаа нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар арга зүйн үндсэн ойлголт, онолын үндэслэлийн талаар мэдлэг нэмэгдүүлэх, мөн хүчирхэг болгох амьдрах ухааны ур чадварыг олгох нийгмийн ажлын арга зүй, хандлага зэрэг талаар мэдээлэл өгөх
Модуль 6 Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал	Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, хүүхдэд тохиолдох эрсдэл, үйлчилгээний зохион байгуулалт, удирдлага, кейс менежмент, урьдчилан сэргийлэлтийн талаар ойлголт өгөх.

Модуль 7

Хүн худалдаалах гэмт хэрэг ба жендэрт суурилсан хүчирхийлэл

Жендэрийн үндсэн ойлголт, түүний эрх зүйн зохицуулалт, үндэсний тогтолцоо, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний төрөл хэлбэр, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг илрүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар мэдлэг нэмэгдүүлэх

Модуль 8

Хүүхэд худалдаалах гэмт хэрэг-илрүүлэлтийн стратеги болон үйл явц

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, зохицуулалтын онцлог, хүүхдийг худалдаалж буй төрөл, хэлбэр, хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулах талаар нэгдсэн ойлголт өгөх.

Модуль 9

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагч төвтэй арга зүй

Сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт, төрөл, илрэх нийтлэг шинж тэмдэг, сэтгэцийн гэмтэл бие махбод, оюун санаа, сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаанд нөлөөлөх сөрөг нөлөө, дахин сэтгэцийн гэмтэд урчлуулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчмуудын талаар ойлголт өгөх

Модуль 10

Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах нь

Ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинжийн ойлголт, үүсэх үе шат, нөлөөлөх хүчин зүйл тухай мэдлэг олгоно. Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжид өртөх шалтгаан, илрэх сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн бэлтгэх, ажлаас халшрах хам шинжийг үнэлэх аргачлал, түүнийг даван туулах сэтгэл зүйн заслын тусламжид суралцах болно.

Модуль 11

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинжүүд, хохирогч/даван туулагчдад илрэх сэтгэл зүйн болон бие махбодын шинжүүдийг ялган таньж мэдэх, сэтгэцийн гэмтлийн тухай ойлголт, төрөл, нөлөөлөх хүчин зүйлс, хүчтэй стресст өгөх цочмог хариу урвалын тухай ерөнхий ойлголт, гэмтлийн дараах стрессийн эмгэг, түүнд хэрэглэх сэтгэл зүйн зөвлөгөөний арга техникүүдийн талаар анхан шатны мэдээлэл өгөх.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДЗМОУБ	“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага
ИНЦ, ТББ	“Ирээдүйн нээлттэй цонх” төрийн бус байгууллага
МУ	Монгол Улс
МУИС	Монгол Улсын Их сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХБ	Хүүхэд хамгааллын бодлого
ХТҮЗ	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хүний эрх

Нэгдсэн Үндэстний Байгууллагын тодорхойлсноор хүний эрх нь арьс үндэс, оршин сууж буй газар, хүйс, үндэстний болон угсаатны угсаа гарал, шашин, хэл, аливаа бусад байдлаас үл хамааран бүхий л хүний угаас салшгүй хэсэг юм. Хүний эрх нь ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, шударга бус харьцаа хандлагаас хамгаалж, хүний суурь эрх чөлөөг хангадаг. Үүнд, үг хэлэх эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх зэрэг иргэний болон улс төрийн, эрүүл мэнд, боловсролын гэх мэт эдийн засаг, нийгэм, соёлын, эрх багтдаг. Хүний эрх нь шударга шүүхээр шүүлгэх гэх мэт хувийн, мөн эмэгтэйчүүд, хүүхдийн гэх мэт бүлгийн эрх байж болно. Хүний эрхийг хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцоор хамгаалдаг. Хүний эрх нь боолчлол, хүний наймаанаас ангид байх, амьд байх, хувийн халдашгүй байдал хэмээн үргэлжилсэн өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд хүний эрх бол аливаа хүнийг хүний зэрэгтэй, нэр төртэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм.

Хүүхэд

Хүүхдийн эрхийн тухай конвенцын зорилгод тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу тэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ.¹

Хүүхдийн эрх

Хүүхдийг хамгаалах зорилгоор тусгайлан хүүхэдтэй холбогдолтой асуудлаар баталсан олон улсын эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн, эрхийг ханган хамгаалах тогтолцооны хүрээнд багтах, тусгай гэрээний болон заншлын эрх зүйн хэм хэмжээний цогцолборыг хэлнэ.²

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

“Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг ойлгоно³

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь үл хайхрах, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэл гэсэн дөрвөн хэлбэрийг авч үзэж байна.

Хүүхдийн эрхэд суурилсан хандлага

Хүүхдийн төлөөх бүхий л үйл ажиллагаанд тухайлбал, хүүхэд ба түүний гэр бүлийн хэрэгцээг үнэлэх, дүн шинжилгээ хийх, үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийхдээ хүүхдийн эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээнд тулгуурлахаас гадна хөгжлийн ерөнхий чиг хандлага, хүүхэдтэй ажилласан туршлагад үндэслэхийг хэлнэ⁴

1 НҮБ, 1989

2 Т.Наранцогт, 2019

3 Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016

4 ХИС, 2007; А.Батхишиг, Хүүхэд хамгаалал, 2022

Хүүхэд хамгаалал	Хүүхдийн эсрэг дарамт, үл хайхрах явдал, хүчирхийлэл, мөлжлөгөөс хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх бүтэц, үйл ажиллагаа бүхий цогц арга хэмжээг хэлнэ (SC, 2007). Хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн хамгаалагдах эрхийг хангахад хүүхэд хамгааллын тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн тогтвортой хэвийн үйл ажиллагаа, хоорондын уялдаа холбоог авч үзнэ.
Хүүхэд хамгааллын бодлого	Хүүхэдтэй харьцдаг, хүүхдийн төлөө ажиллах аливаа байгууллага нь байгууллагын дотоод, гадаад орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслах зогсоох, хохирогч хүүхдийг хамгаалах, тусламж, үйлчилгээ хүргэх, холбон зуучлах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг багтаасан байгууллагын бүх ажилтан, албан хаагчид, тэдэнтэй хамтран ажилладаг хамтрагч, сайн дурын ажилтан нарын дагаж мөрдөх бодлого, дүрэм, зааврыг хэлнэ.
Хүүхэд хамгааллын бодлого ба хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлогын ялгаа	Хүүхэд хамгааллын бодлого нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүчирхийлэлд дахин өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэдэг бол хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого нь хүүхэдд хор хохирол учруулахгүй байх, хүүхдийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн өргөн хүрээг хамаарсан дүрэм, зааврын цогц юм.
Хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд	Хүүхэд хамгааллын тогтолцоо нь нэгдүгээрт, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, хүчирхийллээс хамгаалж, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчин; хоёрдугаарт, хүүхэд хамгааллын салбарыг удирдан чиглүүлэх, үйлчилгээ хүргэх мэргэжлийн зохицуулалт бүхий эрх бүхий, бүтэц, бүхэлдэхүүн; гуравдугаарт, хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сүлжээ; дөрөвдүгээрт, хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ; тавдугаарт чадварлаг бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин; зургаадугаарт, хангалттай нөөц хөрөнгө, зөв хуваарилалт; долоо дугаарт, хүчирхийллийг үл тэвчдэг олон нийт, тэр дунд хүүхдийг ойлгож хамгаалдаг гэр бүл, түүнтэй адилтгах орчин, хамгаалагдах ёстойгоо мэддэг, тусламж хүсэж чаддаг хүчирхэг хүүхэд гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлнэ ⁵
Хүүхэд хамгааллын үйлчилгээний гурван түвшин	Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах хариу арга хэмжээг шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргээх гэсэн гурван түвшинг авч үзнэ.
Шуурхай тусламжийн түвшний үйлчилгээ	Шуурхай тусламжийн түвшний үйлчилгээг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, түүнтэй харилцаа холбоо тогтоох, хүүхдийн эрсдэлийн болон нөхцөл байдлыг үнэлэх гэсэн үе шатуудыг хамруулна.

5 А.Батхишиг, 2011; 2021; 2022; SCUK, 2010; Calder, Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын эвсэл, 2019

Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээ	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээг хаана үзүүлж байгаагаас үл хамаарч, хүүхэд болон гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх, төгсгөх гэсэн үе шатуудаар хүргэнэ. Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээ нь хүүхдийг гэр бүлийнх нь орчинд хамгаалан нөхөн сэргээх, хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалан нөхөн сэргээх гэсэн хоёр хэлбэртэй.
Урьдчилан сэргийлэх түвшний ажил, үйлчилгээ	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажилд хүүхдэд чиглэсэн, эцэг эх, гэр бүлд чиглэсэн, олон нийтэд чиглэсэн, хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хүүхэд хамгааллын судалгаа, нөлөөллийн ажлыг ойлгоно.
Үүрэг хүлээгч	НҮБ-ын ХЭК болон олон улсын хүний эрхийн бусад конвенцуудад тусгагдсан үүргүүдийг хүлээх байгууллага, хүмүүсийг хэлнэ.
Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл, гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг авч үзнэ.
Эрх эдлэгч	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц болон олон улсын хүний эрхийн бусад эрх конвенцуудад тусгагдсан эрхийг эдлэх хүнийг хэлнэ.

НЭГ.

ХҮҮХДИЙН ЭРХ БА ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА

- 1.1 Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлагын үндсэн ойлголт
- 1.2 Хүүхдийн эрх, эрхэд суурилсан аргачлалын ач холбогдол
- 1.3 Хүүхдийн эрх, эрхэд суурилсан онол, арга зүй
- 1.4 Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлагын хэрэглээ, сайн туршлага

1.1

ХҮҮХДИЙН ЭРХ, ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГЫН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Хүний эрх нь хүн бүрийг улс төрийн, эдийн засгийн, эрх зүйн, болон бусад бүх хэлбэрийн хүчирхийлэл, халдлага түрэмгийлэл, ялгаварлан гадуурхалтаас хамгаалахад чиглэсэн олон улсын ёс суртахууны болон эрх зүйн хэмжээнүүдийн, хүний эрхэм чанар, хүний үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг үндэсний болон олон улсын хуульчилсан хэм хэмжээгээр хамгаалахад чиглэгдэнэ (ХЭҮК, 2016, хууд. 83). Хүний амьд явах, эрх чөлөөтэй байх, өмч хөрөнгөтэй байх, түүнийгээ захиран зарцуулах зэрэг нь хүнд угаас заяагдсан эрхүүд бөгөөд хүний оршин амьдрахын үндэс. Энэ эрхүүдийг ямар нэг төр засаг, эрх мэдэлтэн олгодоггүй, хүнийг мэндлэхтэй хамт бий болдог заяагдмал эрхүүд юм (Т.Наранцогт, 2019; ХЭҮК, 2016).

Хүүхдийн эрх нь хүний эрхийн салшгүй хэсэг. Тиймээс хүүхэд бүр хаана, хэний хүүхэд болж төрсөн, хаана амьдарч, сурч, хөгжиж байгаагаасаа үл хамаарч эрхэм чанарыг тээж төрнө. Хүний эрхэм чанар нь дараах дөрвөн үндсэн шинж чанартай (О.Мөнхсайхан, 2015). Үүнд:

1. Хүний эрхэм чанар бол хүн бүрд адилхан байдаг. Тиймээс хүний хэн байхаас нь үл хамааран хүн бүрийн эрхэм чанарыг хүндлэх ёстой;
2. Хүний эрхэм чанар бол хэн нэгэн судлаач судлаад тогтоосон зүйл биш, хүн бүрд өөрөөс нь салгаж үл болох эрхэм чанар байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн норматив зарчим;
3. Хүнээс хүний эрхэм чанарыг салгаж болдоггүй, хүний эрхэм чанарт халдаж болохгүй. Гэмт хэрэг үйлдсэн, ял эдэлж буй хүнийг буруу зүйл хийснийх нь төлөө хүнлэг бусаар харьцаж, зовоон тарчлааж болохгүй. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу хүн бүрийн эрүү шүүлтээс ангид байх, зөрчигдөж болохгүй эрх.
4. Хүний эрхэм чанар бол үл хэмжигдэх үнэт зүйл. Хүн бүр хүн болохынхоо хувьд адилхан үнэ цэнтэй, тэр үнэ цэн нь мөнгө, олонхын санал бодол, сайн муугийн үнэлэмж зэрэг юугаар ч үл хэмжигдэнэ гэсэн үндсэн дөрвөн шинж чанартай хэмээн хууль зүйн профессор О.Мөнхсайхан (2015) тодорхойлсон. Эрхэм чанарыг хүнээс салгаж болохгүй бөгөөд хүн болж төрснийхөө хувьд хүн бүр адил үнэ цэнтэй (О.Мөнхсайхан, 2015; Д.Энхжаргал).

Хүүхдийн эрх гэдэг нь хүүхдийг хамгаалах зорилгоор тусгайлан хүүхэдтэй холбогдолтой асуудлаар баталсан олон улсын эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн, эрхийг ханган хамгаалах тогтолцооны хүрээнд багтах, тусгай гэрээний болон заншлын эрх зүйн хэм хэмжээний цогцолборыг хэлнэ (Т.Наранцогт, 2019, хууд.15).

Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭК)-ийн зорилгод тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу тэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэж хэлнэ (НҮБ, 1989). Хүүхэд бүр насанд хүрсэн хүний нэгэн адил төрсөн цагаас хүний язгуур

эрх, эрх чөлөөг эдэлж, өөрийн эрхэм чанартай байна. Хүүхэд нь бие махбод, оюун ухаан, итгэл үнэмшлийн хувьд насанд хүрэгчидтэй адил, бүрэн хөгжөөгүй тул эрхээ эдэлж, эрхэм чанараа хадгалахад зайлшгүй тусгай хамгаалал, тусламж дэмжлэг шаардлагатай. Энэ тухай НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй” гэж заасан байдаг (НҮБ, 1946). Гэвч, хүүхэд бол эцэг эхийн өмч учраас түүнийг зодох, хэн нэгэнд худалдах, зарцлах, хүүхэд насанд хүрэгчидтэй ижил нөхцөлд ажиллах, хүүхдээр хөдөлмөр хийлгэж өрхийн орлогоо нэмэгдүүлэх зэрэг хүүхдийн эрхийн ноцтой зөрчлийг хэвийн мэт үзэх явдал 18-р зууны сүүл 19-р зууны эхэн үе хүртэл дэлхийн ихэнх улсад түгээмэл байжээ (А.Батхишиг, 2022). Зарим улс оронд хүүхэд худалдах, хүүхэдтэй гэрлэх, хүүхдийг хөдөлмөр эрхлүүлэх, хүчирхийлэх зэрэг хүүхдийн эрхийн зөрчил болон гэмт үйлдлүүдийг хэвийн мэт үзэх, эсхүл хууль эрх зүйн орчинд хориглосон ч хүүхдийн эрхийн ноцтой зөрчил одоо ч тохиолдсоор байна.

19-р зууны эхэнд тодруулбал 1920-иод онд хүүхдийн эрхийг хамгаалах анхны санал санаачилгууд гарч Хүүхдийн эрхийн тунхаглалын эхийг Хүүхдийг Ивээх Санг үндэслэгч Эглантин Жебб боловсруулсан. Энэ тунхаглалыг Хүүхдийн эрхийн Женевийн тунхаглал гэж нэрлэдэг бөгөөд 1959 онд уг тунхаглалын дэлгэрэнгүй хэлбэрийг Хүүхдийн эрхийн тунхаглал гэж НҮБ-аас баталсан. НҮБ-ын Хүүхдийн тунхаглалын үзэл санаан дээр тулгуурлан 1989 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц батлагдсан. Энэхүү конвенц нь дэлхийн бараг бүх улс орон бүрэн болон хэсэгчлэн соёрхон баталсан хамгийн түгээмэл олон улсын эрх зүйн баримт бичигт тооцогддог.

НҮБ-ын ХЭК-д заагдсан хүүхдийн эрхийг тус конвенцод нэгдсэн бүх улс орон хүндэтгэн, эрхийн хэрэгжилтийг хангах биелүүлэх ёстойг ХЭК-ын дараах заалтаас харж болно.

Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй энэхүү Конвенцод заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана (НҮБ, 1990)

НҮБ-ын ХЭК-ийн энэ хоёрдугаар заалтад тусгаснаар конвенцод нэгдэн орсон улс орон бүр өөрийн харьяалалд байгаа хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчийн үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үзэл бодол, нийгэм эдийн засгийн байдал, эрүүл мэнд, бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрийн алагчлалгүйгээр хүүхэд бүрийн эрхийг хүндэтгэн хангах үүрэг хүлээсэн. ХЭК-д нэгдэн орсон улс орнуудын конвенцын хэрэгжилтийг хянах үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хороо нь НҮБ-ын дэргэд ажилладаг. ХЭК-ийг соёрхон баталсан улс нь тухайн улсын хувьд конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жилийн дотор, үүний дараа таван жил тутамд ХЭК-ийн хэрэгжилтийн явц, хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшлийн талаарх тайлангаа НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд хэлэлцүүлэхээр илгээдэг (ХЭҮК, 2016, хууд. 66-67).

ХЭК нь гурван нэмэлт протоколтой. Үүнд: 1. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар, самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол; 2. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцын хоёрдугаар нэмэлт протокол; 3. Мэдээлэл хүргүүлэх журмын тухай Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3-р нэмэлт протокол тус тус багтана (ХЭҮК, 2016; НҮБ, 2021).

Монгол Улс нь НҮБ-ын ХЭК-д нэгдэхээр 1990 оны 1-р сарын 26-нд гарын үсэг зурж, Улсын их хурал (УИХ) тус конвенцийг 1990 оны 7-р сарын 5-нд соёрхон баталж, НҮБ-ын

ХЭК-ийг баталсан эхний арван улсын нэг болсон юм. НҮБ-ын ХЭК-д нэгдэн орсон улс орон бүр конвенцийн хэрэгжилтийг хангах бүх талын арга хэмжээг авахын сацуу, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээдэг. Монгол Улсын УИХ нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай анхны хуулийг 1996 онд баталж, тус хуулийг хорин жил хэрэгжүүлсний дараа 2016 онд Хүүхдийн эрхийг хангах тухай, Хүүхэд хамгааллын тухай гэсэн хоёр бие даасан хуулийг баталж, анхны хуулийг хүчингүй болгосон.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд тус тус батлагдсанаас хойш эдгээр хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дөч гаруй журам шинээр батлагдан, мөрдөгдөж байна. Тэдгээрийн нэг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны А/218 тоотор батлагдсан Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх тухай журам юм. Энэ журмаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх гэсэн гурван түвшинд үзүүлэх тухай нарийвчлан заасан. Энэ нь 2016 оны Хүүхэд хамгааллын тухай хуульд бүрэн гүйцэд тусгагдаж чадаагүй хүүхэд хамгааллын үйлчилгээг тодруулж, хариу үйлчилгээг хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх түвшинд хүргэх эрх зүйн зохицуулалт болсон. Мөн хариу үйлчилгээ нэртэйгээр нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ, холбон зуучлалаар хязгаарлагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээг хүчирхийлэлд өртсөн хүүхдийг нөхөн сэргээх, хүүхдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн шууд бус үйлчилгээг хүүхэд хамгааллын үйлчилгээгээр өргөтгөж, тэдгээр хамгааллын зардлаас санхүүжих боломжийг бүрдүүлсэн юм.

Хүүхдийн эрхэд суурилсан хандлага нь олон улсын хууль тогтоомжид тодорхойлсон хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хүүхдийн эрхийн зарчмуудыг төсөл хөтөлбөрийн удирдлага, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээнд ашиглахыг хэлнэ (ХИС, 2007, хууд. 38). Хүүхдийн эрхийн үндсэн зарчимд хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих эрхийг хангах, хүүхдийн дээд ашиг сонирхлыг анхаарах, хүүхдийг үл ялгаварлах, хүүхдийг оролцуулах гэсэн дөрвөн зарчим хамаарна. Эдгээр дөрвөн зарчмын тухай тайлбарыг Шигтгээ 1-с харна уу.

Шигтгээ 1. Хүүхдийн эрхийн үндсэн дөрвөн зарчим

Хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих эрх

ХЭК-ийн зургаадугаар зүйлд “Оролцогч улсууд хүүхдийн амьд явах жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрнө”; “Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжил бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана” гэж тус тус заасан (НҮБ, 1989).

Хүүхдийн дээд ашиг сонирхол

Хүүхдийн талаар явуулж буй бүхий л үйл ажиллагаа нь тэдний дээд ашиг сонирхлыг дээдэлсэн байх ёстой гэж ХЭК-ийн гуравдугаар зүйлд заасан (НҮБ, 1989). Хүүхдийн дээд ашиг сонирхол гэдэг нь хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээ хүүхдэд эерэг нөлөө үзүүлэх ёстойг хэлнэ. Хүүхдэд ээлтэй, хүүхдийн асуудалд мэдрэмжтэй байх практикийг хүүхдийн төлөө хийх бүхий л үйлчилгээндээ нэвтрүүлнэ гэсэн үг. Энэ зарчмыг хуулийг өөрөөр тайлбарлах эсхүл ХЭК-д дурдсан эрхийг хэрэгжүүлэхэд саад болоход хүргэх байдлаар ашиглах ёсгүй (ХИС, 2007, хууд. 90).

Үл ялгаварлал

Ямар ч үед хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, яс үндэс, шашин шүтлэг, иргэний харьяалал зэргээс үл хамаарч хүүхэд бүр ямар нэг ялгаварлалгүйгээр эрхээ эдлэх эрхтэй тухай ХЭК-ийн хоёрдугаар зүйлд заасан (НҮБ, 1989; ХИС, 2007). Хүүхэд хамгааллын салбарт хүүхдийг үл ялгаварлах зарчим нь онцгой ач холбогдолтой (ХИС, 2007, хууд.90).

Оролцоо

ХЭК-ийн 12 дугаар зүйлд хүүхдийн нас болон хөгжлийн онцлогийн дагуу хүүхдийн үзэл бодол, санаа зовж буй зүйлийг сонсох, хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангагдах эрхийн тухай заасан. Энэ зарчмын онцлог нь хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүүхдийг насанд хүрэгчид сонсох ёстойг чухалчилдаг (ХИС, 2007, хууд.90).

Шигтгээ 1-т заасан хүүхдийн эрхэд суурилсан хандлагын хүрээнд баримтлах дөрвөн зарчмын тухай өгүүлсэн. Эдгээр зарчмыг хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаа, үйлчилгээ, хөтөлбөр, төслийн үе шат бүрд анхаарахад хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх үүрэг хүлээгчид болон эрх эдлэгчдийн оролцоо чухал.

Үүрэг хүлээгч гэж НҮБ-ын ХЭК болон олон улсын хүний эрхийн бусад конвенцод тусгагдсан үүргүүдийг хүлээх байгууллага, хүмүүсийг хэлдэг бол **эрх эдлэгч** гэж НҮБ-ын ХЭК болон олон улсын хүний эрхийн бусад эрх конвенцод тусгагдсан эрхийг эдлэх хүнийг хэлнэ. Эрх эдлэгч нь өөрийн эрхээ шаардах боломжоор хангагдаж, үүрэг хүлээгчид нь хүлээсэн үүргээ биелүүлэх тал дээр хариуцлага хүлээж байх ёстой (ХИС, 2007).

Зураг 1. Хүүхдийн эрхэд суурилсан хандлагын хоёр түлхүүр ойлголт



Зураг 1-т хариуцлага, оролцоо гэсэн ойлголтуудыг хүүхдийн эрхэд тулгуурласан хандлагын хоёр түлхүүр ойлголт болохыг дүрсэлсэн. Энэ хоёр ойлголтууд нь харилцан хамааралтай ойлголтууд.

Хүүхдийн эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэхэд үүрэг хүлээгчид хүүхдийн эрхийг хүндэлж, хамгаалж, биелүүлэх хариуцлага хүлээдэг бол эрх эдлэгчид нь үүрэг хүлээгчдийг хариуцлагатай, үүргээ биелүүлдэг болгоход нөлөөлөх, эрхийн хэрэгжилтэд өөрсдөө оролцох хэрэгтэй гэсэн санааг Дүрс 1-т харуулсан. Дүрс 1-ийн голд хүний эрхийн үндсэн зарчмуудыг байрлуулсан. Өөрөөр хэлбэл хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх хүн бүхэн хүний эрхийн суурь зарчмуудыг мөрдлөг болгоно. Хүний эрх нь түгээмэл, салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай байх зэрэг хүний эрхийн суурь зарчмуудад тулгуурлана. Эдгээр хүний эрхийн суурь зарчмуудын тайлбарыг ХЭҮК-ийн танилцуулснаар Хүснэгт 1-т дэлгэн харуулж байна (ХЭҮК, 2016, хууд. 7).

Хүснэгт 1. Хүний эрхийн үндсэн зарчмууд

ХҮНИЙ ЭРХИЙН СУУРЬ ЗАРЧМУУД	
<p>Тэгш байх Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.</p> <p>Ялгаварлан гадуурхахгүй байх Арьс үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал зэрэг [нийгэмд эзлэх байр суурь] - статусаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй.</p> <p>Түгээмэл байх Энэ дэлхийн аль ч өнцөгт байгаа аливаа эмэгтэй, эрэгтэй хүн, хүүхэд нь хүний төрлийг олж төрсний хувьд хүний эрхийг эдлэгч болдог. Тиймээс хүний эрх нь ертөнцийн өнцөг, булан бүрд амьдарч байгаа хүн бүрд хамаатай. Иймд бүх хүн аливаа ялгаварлалгүйгээр тэгш хүртэх түгээмэл шинж чанартай.</p> <p>Салшгүй байх Хүн оршин байгаа цагт эрхийг хүнээс тусгаарлах, салгах боломжгүй бөгөөд хүнээс салшгүй ойлголт юм.</p> <p>Хүн үнэ цэн, нэр төртэй байх Хүний үнэ цэнэ, нэр төр нь бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ гэдгийг баталгаажуулдаг. Бүх хүн нас, соёл, угсаа гарал, арьс өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, хэл, боломж, чадвар, нийгэм эзлэх байр суурь, иргэний харьяалал болон улс төрийн үзэл бодлоосоо үл хамааран ижил хүндлэлийг хүлээнэ.</p>	<p>Хуваагдашгүй байх Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг бүх эрхүүд нэгдмэл хуваагдашгүй байдаг.</p> <p>Харилцан хамааралтай байх Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрд, амьдралын бүхий л хүрээг хамардаг. Өөрөөр хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө, нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрах өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг.</p> <p>Хариуцлага тооцох <i>Төртэй хариуцлага тооцох</i> Хүний эрхийг төр өөрийн үзэмжээр өгдөггүй. Төр нь хүний эрхийг хүндэтгэх, хангахаас татгалзах, эсхүл хэсэг хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангаад бусад хүмүүсийн эрхээс татгалзах ёсгүй.</p> <p>Хувь хүнтэй хариуцлага тооцох Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх болон хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй.</p> <p>Бусад этгээдтэй хариуцлага тооцох Корпорац, төрийн бус байгууллага, сан, боловсролын байгууллага зэрэг нийгмийн бусад бүх институци, бүрэлдэхүүн хэсгүүд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргийг хүлээнэ.</p>

Эх сурвалж: ХЭҮК, 2016, хүүд.7

Хүснэгт 1-т тайлбарласан хүний эрхийн суурь зарчмууд нь хүүхдийн эрхийг хангах суурь зарчмууд болно. Тиймээс, хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээгчид болон эрхээ шаардах эрх эдлэгчид нь хүний эрхийн тулгуур зарчмуудыг хүүхдийн төлөөх бүхий л үйл ажиллагаандаа баримтлах шаардлагатай.

1.2

ХҮҮХДИЙН ЭРХ, ЭРХЭД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

НҮБ-ын ХЭК нь батлагдаад 30 гаруй жил болж, хүүхдийн эрхийг хангах олон улсын хийгээд үндэсний хууль тогтоомж батлагдсан ч хүүхдийн эрхийн зөрчил тохиолдсоор байна. Хүүхдийг эцэг эхийн өмч гэж үзэх, хүүхдээр хөдөлмөр эрхлүүлж орлого олох, хүүхэд хүний наймааны хохирогч болох, зэвсэгт мөргөлдөөнд хөвгүүдийг дайчлах, охидтой гэрлэх, охидын бэлэг эрхтнийг гэмтээх зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл, бурангуй ёс заншлын улмаас дэлхийн өнцөг булан бүрд олон зуун хүүхдийн эрх ноцтой зөрчигдсөөр байна. Зарим улс оронд ядуурал, ажилгүйдэл, архидалт, гэр бүл салалт, хорт зуршил, гамшиг зэрэг нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн асуудал, нөгөө талаас хүүхдийг эцэг эхийн өмч гэх үзэл, хүүхдийн асуудлыг үл тоох хандлагаас улбаатай хүүхдийн эрхийн зөрчил гарсаар байна. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээгчдийн зүгээс нийгэм эдийн засгийн байдал, ард иргэдийн амьдралын түвшинтэй холбон, хэрэгцээнд чиглэсэн хөгжлийн хандлагаар асуудлыг харах явдал байсаар байна. Энэ нь хүний хэрэгцээ хязгааргүй, хүн бүрийн хэрэгцээг хангах боломж нөөц байхгүй гэх шалтгаанаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эсхүл хүний эрхийн суурь зарчмуудыг дагаж мөрдөх боломж хараахан бүрдээгүй гэх шалтгаанаар хүүхдийн эрхийг зөрчлийг хүлээн зөвшөөрөх явдал нэлээдгүй байна.

Нөгөө талаас хууль ёсны дагуу эрхээ эдлэх эрхтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид нь үүрэг хүлээгчдээс хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах эрхээ шаардах, хариуцлага нэхэж чадахгүй байна. Энэ нь хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад үүрэг хүлээгчдийн үзэл хандлага давамгайлах, эрх эдлэгч хүүхдийн оролцоог хязгаарлах, тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг үл мэдэрсэн бодлого, шийдвэрийг гаргах, хэрэгжүүлэхэд хүргэх эрсдэлийг бий болгоно. Эдгээр асуудлыг шийдэхэд хүүхдийн төлөөх аливаа үйл ажиллагаа, үйлчилгээ, хөтөлбөр, төсөлд хүүхдийн эрхийн мэдрэмжтэй хандаж, хүүхэд төвт арга зүйг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байгааг илэрхийлж байна. Хүүхэд төвт арга зүй гэдэг нь хүүхдийн хэрэгцээ, дээд ашиг сонирхлыг шийдвэр гаргах, дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах үйл явцдаа анхаарахыг хэлнэ. Хүүхдийн эрхийн мэдрэмжтэй, хүүхэд төвт арга зүйг нэвтрүүлснээр хүүхдийг эрх эдлэгч хувь хүн гэж үзэн түүний нас, ойлгох чадварт нийцүүлэн үзэл бодлыг нь сонсон, өөрт нь хамааралтай шийдвэр гаргахад оролцуулан, идэвхтэй оролцогч байдлаар хүүхэдтэй харилцах боломжтой болно.

1.3

ХҮҮХДИЙН ЭРХ, ЭРХЭД СУУРИЛСАН ОНОЛ, АРГА ЗҮЙ

1997 онд НҮБ-аас олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд үндэслэн хөгжлийн үйл явцыг тодорхойлох, төлөвлөх, боловсруулах, мониторинг хийхэд баримтлах үзэл баримтлалын, дүн шинжилгээний болон арга зүйн хүрээг танилцуулж, хүний эрхэд суурилсан үзэл хандлагын тухай үзэл баримтлал хөгжиж эхэлсэн (ХЭҮК, 2016, хууд. 80). Энэ үзэл хандлагыг энгийнээр хэлбэл, олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандарт зарчмуудыг хөгжлийн бүхий л үйл явц, тухайлбал, хөтөлбөр, стратеги, бодлогод нийцүүлэх явдал юм. Нөгөө талаас олон улсын хэм хэмжээг соёрхон баталсан улс орнуудын засгийн газар, төрийн байгууллагуудад хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах, хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүд эрхийнхээ төлөө тэмцэхэд нь дэмжлэг үзүүлэх үүрэг хариуцлагын тухай өргөн цар хүрээтэй ойлголт төлөвшүүлэх явдал гэж үзсэн (ХЭҮК, 2016, хууд.80).

Хүний эрхэд суурилсан хандлага нь эрх эдлэгч, үүрэг хүлээгч гэсэн хоёр бүлэг оролцогч талуудын эрх тэгш, тэнцвэртэй харилцаатай холбоотой. Эрхэд суурилсан хандлагаар хүний хөгжил ба эрх гэсэн хоёр ойлголт нь харилцан бие биеэ нөхцөлдүүлдэг болохыг хүлээн зөвшөөрдөг. Мөн хөгжлийн тухай бодлого, хөтөлбөрт эрхэд суурилсан арга зүйг нэвтрүүлснээрээ тэгш бус байдал, ялгаварлан гадуурхал, эрх мэдлийн тэнцвэргүй байдал зэрэг хөгжлийн тулгамдсан асуудлыг хүний эрхийн мэдрэмжтэй, хүн төвт хөгжлийн зарчимд тулгуурлан шийдэж, тогтвортой хөгжлийг бүтээнэ гэж үздэг.

Хүний хэрэгцээнд чиглэсэн уламжлалт хандлагын оронд эрхэд суурилсан хандлагыг баримталснаараа эрх эдлэгч нь эдлэх ёстой эрхээ эдлэхийн сацуу аливаа хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хууль ёсны дагуу хамгаалагдах ёстой гэдгийг үүрэг хүлээгчдэд сануулж, эрх эдлэгчдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг хүлээгчдийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарал хандуулна (ХЭҮК, 2016; ХИС, 2007). Ингэснээр эрхийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын эрхийн хэрэгжилттэй холбоотой санал бодлоо илэрхийлэх боломжийг нэмэгдүүлэх, эрхийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлийг даван туулах, эрх эдлэгчийг хүчирхэг болгох, оролцоог хангах, үүрэг хүлээгчдийг хариуцлагатай болгох, үл ялгаварлах, нийгмийн эмзэг бүлэгт анхаарал хандуулах зэрэг асуудалд илүү анхаарах болно.

Хүүхдийн эрхэд суурилсан хандлага, арга зүйг хүүхдийн төлөөх бүхий л үйл ажиллагаанд тусгаснаар хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээгчдийн хариуцлага нэмэгдэж, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч эрх эдлэгчийнхээ хувьд эрхээ шаардах, эрхийн хэрэгжилтийн явцад оролцох боломж нэмэгдэнэ. Хүүхдийн хэрэгцээг хангахад чиглэсэн уламжлалт хандлагыг сөрөн танилцуулагдсан хүүхдийн эрхэд суурилсан хандлага нь хүүхдийн эрхийг хангах эрх зүйн орчин болон үүрэг хүлээгчийн хариуцлага, эрх эдлэгчийн оролцоог дэмждэг. Тиймээс хэрэгцээнд суурилсан хандлагаас илүү нөлөөтэй гэж үздэг.

Хэрэгцээнд суурилсан ба эрхэд суурилсан гэсэн хоёр үзэл баримтлалын суурь болох хэрэгцээ ба эрх гэсэн ойлголтууд нь зарчмын ялгаатай. Хэрэгцээ нь хариуцлагыг дагуулдаггүй бөгөөд

хэрэгцээг эрэмбэлж, нэг хэрэгцээг нөгөө хэрэгцээнээс түрүүлж анхаарах хэрэгтэй гэж үзэх хэрэгцээний онол ч байдаг. Мөн хэрэгцээ нь хоорондоо холбоотой ч бие биеэсээ хамааралтай байх шаардлагагүй. Харин эрх нь хариуцлагатай хамт олгогдох бөгөөд бүх эрх адил чухал шинжтэй. Эрхүүд бие биеэсээ хэрхэн хамаарч байгаагаас хамаарсан ямар нэг дараалсан шатлалыг тогтоодоггүй. Хэрвээ нэг эрхийг үгүйсгэвэл энэ өөр эрхэд нөлөөлөх магадлалтай. Жишээ нь: хүүхдийн өөрийгөө илэрхийлэх эрхийг үгүйсгэж, дэмжихгүй бол ийм нөхцөлд орсон хүүхэд хэн нэгнээс тусламж авч мэдэхгүй, эсхүл чадахгүй хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй.

Эрхэд суурилсан хандлагыг бусад хандлагатай харьцуулсан ялгааг дараах Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Эрхэд суурилсан болон бусад хандлага

Эрхэд суурилсан хандлага	Бусад хандлага
Үйл ажиллагаа нь зайлшгүй хийгдэхээр хууль тогтоомжид тусгагдсан байдаг.	Үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр эсхүл сонголтоор хийх боломжтой байна.
Хууль ёсны шаардлага тавих, албан ёсны эрхтэй байдаг.	Хүмүүст олон хэрэгцээ байх бөгөөд тэдгээр хэрэгцээг нэн тэргүүнд хэрэгтэйгээр нь ангилна.
Ядуу хүн эрх эдлэх эрхтэй хүний хувьд тусламж хүртэх хууль ёсны эрхтэй.	Ядуу хүн бол буяны ажлын объект адил, тусламж дэмжлэг хүртэх ёстой гэж үздэг.
Хүн бүр өөрийн нөөц боломжоо гүйцэлдүүлэх буюу туслалцаа дэмжлэг авах адил тэгш эрхтэй.	Зарим хүмүүс орхигдож болно. Өөрөөр хэлбэл зорилтод бүлгийн эзлэх хувь зуун хувиас бага байна.
Хөгжлийн ажилд хамрагдах хүмүүс нь эрхийн дагуу идэвхтэй оролцогчид байна.	Хөгжлийн явцад хамрагдсан хүмүүсийг идэвхгүй, тусламж хүртэгсэд гэж үзнэ. Хөтөлбөр буюу төслийн үр ашгийг дээшлүүлэх үүднээс тэднийг урьж оролцуулахыг чармайна.
Эрх бол түгээмэл бөгөөд салшгүй тул түүнийг хүнээс салгаж эсхүл бүрхэгдүүлж болохгүй.	Соёл, ёс заншлын хүрээнд зарим хэрэгцээг хүлээн зөвшөөрөхгүй байж болно.
Хүний эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй эрх мэдлийн тогтолцоог өөрчлөх ёстой.	Эрх мэдлийг тогтолцоог өөрчлөх хүн их хүндрэлтэй бөгөөд үүнтэй зохицон ажиллах уян хатан арга замыг олох хэрэгтэй.
Хөгжлийн хөтөлбөрт оролцогчид нь эрхээ эдлэгчдийг өөрсдийн эрх ашгийг шаардахад болон олон нийтийн шийдвэр гаргахад оролцоход нь дэмжлэг үзүүлэх ёстой	Хөгжил бол техникийн мэдлэг чадвар дээр суурилдаг үйл явц бөгөөд, хамгийн сайн мэдлэгтэй мэргэжилтнүүд хөтлөн удирдах ёстой.
Хэдийгээр зарим нөхцөлд аль нэг эрхийг илүүд үзэх шаардлага тулгардаг ч бүх эрх харилцан хамааралтай, аль нэгнээсээ илүү дээр байр эзлэхгүй зарчим үйлчилнэ.	Хэрэгцээ нь хоорондоо ялгаатай бөгөөд зарим нэг хэрэгцээ нь бусад хэрэгцээтэй харьцуулна.

Хүснэгт 2-т харуулсанчлан эрхэд суурилсан хандлага нь төлөвлөж буй үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зайлшгүй хийх, тавьж буй шаардлага нь хуулийн хүрээнд албан ёсны байх, хүн бүр өөрийн нөөц боломжоо дайчлах мөн тусламж дэмжлэг авах, түүнчлэн ядуу хүн ч мөн эрх эдлэгч хүний хувьд тусламж дэмжлэгийг гуйж биш эрхийнхээ дагуу авах, хөгжлийн үйл ажиллагаанд оролцогч талууд эрхийнхээ дагуу идэвхтэй оролцох, хүний эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах шийдвэр гаргах бүх түвшинд нөлөөлөх, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид хөтөлбөртэй холбоотой эрхээ эдлэгчдийг оролцуулах, бүх эрх харилцан хамааралтай, нэг эрхийг нөгөө эрхийн дээр тавихгүй гэх зарчмуудыг багтаажээ. Эрхэд суурилсан хандлага нь уламжлалт хэрэгцээнд суурилсан хөгжлийн хандлагаас ялгаатай бөгөөд хөгжлийн төвд тухайн хөгжлийн хөтөлбөрийг үр шимийг хүртэгчдээ авч үздэг бол бусад хандлага нь тэр

бүр үйл ажиллагааныхаа төвд үр шимийг хүртэгчдийн эрхийг тавьж, тэдгээр эрхийг хангахыг чухалчилдаггүй болохыг Хүснэгт 2-т илтгэжээ.

1993 онд Вена хотноо дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хэлэлцэж түүнийг дахин баталж, хөгжлийн бүхий л үйл явцад тухайн хөгжлийн үр шимийг хүртэгчдийн идэвхтэй, чөлөөтэй, утга учиртай оролцоог хангасан тохиолдолд хөгжил жинхэнэ утгаараа үр дүнгээ өгнө гэж заасан (ХИС, 2007, хууд. 94). Энэ хандлагыг хөгжлийн бүхий л шатанд анхаарч үзэх чиг баримжааг хөгжлийн байгууллагууд улс орнуудад танилцуулсан юм.

Эрхэд суурилсан хандлага гэдэг нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд үндэслэн хүний эрхийг хангах ба хамгаалахад чиглэгдсэн хүний хөгжлийн цогц үзэл баримтлалын загвар юм. Эрхэд суурилсан хандлагыг баримтлах үед олон улсын [бүс нутаг, үндэсний] хүний эрхийн тогтолцооны хэм хэмжээ, норм дүрэм, зарчмыг хөгжлийн бодлого, төлөвлөгөө ба үйл явцтай холбодог (ХИС, 2007, хууд. 94). Өөрөөр хэлбэл олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээнд мөрдөх хүний эрхийн баримт бичгүүдэд тусгасан хүний эрхтэй холбоотой заалтуудын хоорондын уялдаа холбоог тогтоох ажлаас эхлээд хүний эрхийг тусгасан хөгжлийн загварыг нийгмийн бүхий л салбарын бодлого чиглэл, журам, дүрэмд тусгаж уялдаа холбоог хангахад анхаарна гэсэн үг.

Эрхэд суурилсан хандлагын бас нэг онцлог нь эрхээ эдлэгчид ямар эрх эдлэх ёстой тухайгаа, нөгөө талаас үүрэг хүлээгчид ямар үүрэг хүлээдэг тухайгаа мэдэх, түүнийгээ хэрэгжүүлэхэд анхаарна. Ингэснээр хувь хүн, гэр бүл, олон нийт, улсын ба орон нутгийн төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн, олон улсын байгууллага, тэдгээрийн ажилтан албан хаагч зэрэг бүх түвшний үүрэг хүлээгчдийн хүүхдийн эрхийг хангах үүрэг тодорхой болно (ХИС, 2007). Нөгөө талаас хууль тогтоомж, бодлого, албан байгууллагын дүрэм журам, ажлын заавар зэргийг эргэн харж, эрхэд суурилсан өөрчлөлт, хэрэгжилтийн механизмыг бий болгож хөгжүүлэхэд анхаарснаар үүрэг хүлээгчдийн хариуцлагыг үнэлж хянахад хялбар болно гэж үздэг.

Эрхэд суурилсан арга зүй нь буяны тусламж үзүүлэхээс илүүтэйгээр хүнийг чадавхжуулах, эрх мэдэлжүүлэх стратегийг чухалчилдаг. Хүмүүс өөрсдийн амьдралаа өөрчлөх, өөрийн орон нутгаа өөд нь татах буюу өөрийн хувь заяандаа нөлөөлөхөд зайлшгүй хэрэгтэй эрх мэдэл, чадавхтай, мөн боломжтой байх нь эрхэд суурилсан чадавхжуулах стратегийн зорилго юм (ХИС, 2007). Үүний тулд эрх эдлэгчид хөгжлийн үйл ажиллагаа, үйлчилгээнд идэвхтэй, утга учиртай оролцох ёстой. Түүнчлэн хэн болж төрснөөс тодруулбал арьс өнгө, шашин шүтлэг, яс үндэс, хэл, соёл, хүйс, эрүүл мэнд зэргээс үл хамаарч хүн болсныхоо хувьд хүн бүхэн түүнд заяагдсан эрхээ эдлэх ёстой. Тиймээс эрхээ хасуулсан хоригдол, үндэсний цөөнх, цагаач иргэд, бусад тусгаарлагдсан, эмзэг бүлгийн хүүхэд, насанд хүрсэн хүн бүхэн хөгжлийн үйл явцад ямар нэг ялгаварлан гадуурхалд өртөхгүйгээр ижил тэгш оролцох эрхтэйг эрхэд суурилсан хандлага чухалчилдаг.

Хүний эрхэд суурилсан хандлагаас эхтэй хүүхдийн эрхэд суурилсан арга зүйг хүүхдийн төлөөх бүхий л хөтөлбөр, төсөл, хөгжлийн ажилд тусгах ёстойг ХИС-гийн Хүүхдийн эрхэд суурилсан арга зүйн гарын авлагад дараах байдлаар сийрүүлсэн байна (ХИС, 2007). Үүнд:

- Хүүхдийг эрхээ эдлэгч гэдгийг хүлээн зөвшөөрөх;
- Засгийн газар нь гол үүрэг хүлээгч бөгөөд хариуцлага хүлээх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх;
- Хүүхдийн эрхийг бүхэлд нь авч үзэж, тэнцвэртэй бус эрх мэдлийн бүтцэд анхаарал хандуулах;

- Хүүхдийн эрхийг хангах үүднээс зорилгоо тодорхойлох;
- Тогтвортой үр дүнд зорилгоо чиглүүлэх;
- Хууль эрх зүй ба бусад шинэчлэлийг дэмжих, хүүхдийн эрхийг дэмжих эвсэл ба түншлэлийг бий болгох гэж тус тус заасан (ХИС, 2007, хууд.93).

Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн эрхэд суурилсан хандлагын тухай 2004 онд хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчдад зориулсан анхны сургалтыг зохион байгуулсан. Дараа нь 2007 онд олон улсын ХИС-гаас нийтэлсэн Хүүхдийн эрхэд суурилсан арга зүй гарын авлагыг орчуулан олны хүртээл болгосон. Хүүхдийн эрхэд суурилсан арга зүй сэдэвт сургалтын гарын авлагадаа эрхэд суурилсан хүүхдийн эрхийн хөтөлбөр, төслийг боловсруулан хэрэгжүүлэхдээ анхаарах дараах зөвлөмжийг өгсөн (ХИС, 2007, хууд.93). Үүнд:

- Хүүхдийн эрх зөрчигдөж буй цэгээс хөтөлбөр, төслөө эхлэх;
- Хүүхдийн эрхийг бодит болгохын төлөө ажиллах;
- Хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээгчдийг тодорхойлох;
- Үүрэг хүлээгчдийн үйл ажиллагаанд анхаарах;
- Зарим үүрэг хүлээгчдийн үйл ажиллагаа бусад үүрэг хүлээгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг болно. Тиймээс хамтын ажиллагааг чухалчлах;
- Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн ерөнхий “том дүр зургийг” харах;
- Үйл ажиллагаандаа хүүхдүүдийг оролцуулах;
- Хүүхдийн эрх хамгийн ихээр зөрчигдөж байгаа болон хамгийн эмзэг, алслагдаж тусгаарлагдсан хүүхдийн нөхцөл байдалд голлон анхаарах;
- Хүүхдийн дээд ашиг сонирхол нь урт болон богино хугацаанд юу байж болох асуудал дээр бодлого, үйлчилгээ, хөтөлбөрөө тулгуурлах зэрэг зөвлөмжийг өгч байсан нь одоо ч хүүхдийг эрхийг хангах чиглэлээр төсөл хөтөлбөр, үйл ажиллагаандаа баримтлахад үнэ цэнээ алдаагүй зөвлөмжүүд юм.

1.4

ХҮҮХДИЙН ЭРХ, ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГЫН ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Монгол хүүхдүүд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж бие даасан илтгэл бичиж, илтгэлээ НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд 2015 онд илгээсэн. 11-18 насны нийт 108 хүүхэд илтгэлийг бичихэд оролцсон бөгөөд тэд Монгол Улсын дөрвөн бүсийг төлөөлүүлэн 3,285 хүүхдийг хамруулсан судалгаа хийн, хүүхдийн эрхийн хэрэгжилт, эрхийн зөрчлийг тодорхой жишээ баримттай харуулсан илтгэлийг бичиж, тус илтгэлээ НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд танилцуулсан (ХИС, ХХТ, ДЗМОУБ, 2015). Энэ нь хүүхдүүд эрх эдлэгчид болохынхоо хувьд өөрсдийнхөө эрхийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээгчид болон эрхийн хэрэгжилтийг хянах олон улсын байгууллагад танилцуулж, эрхээ хангахыг шаардсан сайн туршлага болох юм.

Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрөөс 2020 оноос эхлэн “Ардчиллын төлөөх шинэ үе” төслийг НҮБ-ын “Ардчиллыг дэмжих сан”-гийн санхүүжилтээр нийслэлийн

Баянгол, Чингэлтэй дүүрэг болон Ховд аймагт үндэсний болон орон нутгийн төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Энэ төсөл нь ардчиллын үнэт зүйлс, иргэний оролцоо, сонгуулийн үйл явцын талаарх хүүхэд, залуучуудын боловсролыг дээшлүүлэх замаар ардчилсан засаглалыг одоо ба ирээдүйн сонгогчдын мэдлэг үйлдлээр дамжуулах бэхжүүлэх зорилготой (ХИС, 2022). Уг төслийн хүрээнд “Ардчиллын үнэт зүйл” сургалтын хөтөлбөр боловсруулж, тус сургалтын агуулгад хүүхэд, залуучуудын амьдралд ойрхон жишээнүүдээр дамжуулан хүүхдүүд өөрсдийн амьдарч буй орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдүүлэх, аливаа асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй хандах, хуулийн зүйл заалтуудыг ашиглаж сурах, асуудлаа шийдвэрлүүлэхэд дуу хоолойгоо хүргэх чадварыг эзэмшүүлэх тухай зааж өгчээ (ХИС, 2022). Энэ нь хүүхэд, залуучуудад тэдний амьдралд нөлөөлөх засаглал, засаглалын хэлбэрүүдтэй танилцах боломжийг олгосон чадавхжуулах төслийн сайн жишээ. Учир нь тус төслийн хүрээнд хүүхдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалтыг зохион байгуулсны дүнд “Залуу сонгогчдын клуб”-ын сурагчид ардчилсан засаглал, түүний хэлбэрүүд, төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд хэрхэн оролцох, өөрсдийн нөхцөл байдлын талаарх хяналт судалгаа, нөлөөллийн ажил хийх чухал чадваруудыг хүүхэд ахуй насандаа эзэмшиж, амьдрал дээр туршиж эхэлсэн (ХИС, 2022).

Монгол Улсын Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл (ХТҮЗ)-ийн гишүүд, салбар яам, газрууд, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээгчдийн уулзалт, зөвлөгөөнийг сүүлийн жилүүдэд тогтмол зохион байгуулж байна. Эдгээр чуулга уулзалт, зөвлөгөөнүүд нь зөвхөн хүүхдийн асуудал хариуцсан салбар, байгууллагуудаар хязгаарлахгүй, бүх салбар, орон нутгийн түвшинд хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр өмнө хийсэн ажлаа тайлагнаж, хойшид хийх ажлаа хэлэлцэж байгаа нь хүүхдийн эрхийг хангах чиглэлээрх үүрэг хүлээгчдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, туршлага солилцох, үүрэг хүлээгчдийн үүрэг хариуцлагыг сайжруулах боломжийг олгосон үндэсний хэмжээний сайн туршлагын жишээ юм.



Мэдлэг шалгах асуултууд

1. Хүний эрхийг хүний эрхэм чанартай холбон тайлбарлана уу.
2. Хүүхдийн эрх гэж юуг хэлэх вэ?
3. Эрхэд суурилсан хандлага бусад хандлагаас юугаараа ялгаатай вэ?
4. Хүүхдийн эрхэд тулгуурласан хандлагын хоёр тулгуур ойлголт нь ямар ойлголтууд байдаг вэ? Тэдгээрийг яагаад эрхэд суурилсан хандлагын тулгуур ойлголтууд гэж үздэг вэ?
5. Хүүхдийн эрхэд суурилсан төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхдээ юу юуг анхаарах хэрэгтэй вэ?

ХОЁР

ХҮҮХДИЙН ХАМГААЛАГДАХ ЭРХ

- 2.1 Хүүхдийн хамгаалагдах эрх, түүний үндсэн ойлголт
- 2.2 Хүүхдийн хамгаалагдах эрх түүний ач холбогдол
- 2.3 Хүүхдийн хамгаалагдах эрх, түүний үндэслэл
- 2.4 Хүүхдийн хамгаалагдах эрхийг хэрэгжүүлэх арга зүй, аргачлал
- 2.5 Хүүхдийн хамгаалагдах эрхийн талаар бусад улс орны сайн туршлага

2.1

ХҮҮХДИЙН ХАМГААЛАГДАХ ЭРХ, ТҮҮНИЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Хүүхэд хамгаалал ба хүүхдийн эрх нь хоорондоо ялгаатай ойлголтууд. Хүүхдийн эрх гэдэг нь хүүхдийг хамгаалах зорилгоор тусгайлан хүүхэдтэй холбогдолтой асуудлаар баталсан олон улсын эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн, эрхийг ханган хамгаалах тогтолцооны хүрээнд багтах, тусгай гэрээний болон заншлын эрх зүйн хэм хэмжээний цогцолборыг хэлнэ (Т.Наранцогт, 2019, хууд.15). Харин хүүхдийн хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийн эсрэг дарамт, үл хайхрах явдал, хүчирхийлэл, мөлжлөгөөс хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх бүтэц, үйл ажиллагаа бүхий цогц арга хэмжээг хэлнэ (ХИС, 2007). Хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн хамгаалагдах эрхийг хангахад хүүхэд хамгааллын тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн тогтвортой хэвийн үйл ажиллагаа, хоорондын уялдаа холбоо чухал үүрэгтэй.

Энгийнээр тайлбарлавал хүүхдийн эрх нь хүүхэд бүрийн эрхийг хангах үүрэг хүлээгчдийн үүрэг, хариуцлагыг тухай тодорхойлдог бол хүүхэд хамгаалал нь хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хохирогч хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ хүргэх, хохирогч хүүхэд дахин эсхүл ижил төрлийн хүчирхийллээр бусад хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бүтэц, зохицуулалт, бэлтгэгдсэн боловсон хүчин, үйлчилгээ, дэмжих орчин бүхий тогтолцоо юм.

“Хүүхэд онцгой халамж, туслалцаа авах эрхтэй, баталгаатай гэр бүлээс гарсан [төрсөн] ба бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх эрхтэй” (НҮБ, 1946) гэж Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйлд заасан.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тунхаглалд (НҮБ, 1959) “хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай” гэж тунхагласан.

Хүүхэд нь бие бялдар, оюун ухааны хувьд гүйцэд өсөж хөгжөөгүй тул яс үндэс, хүйс, соёл, бусад нөхцөл байдлаас үл хамааран төрийн зүгээс онцгойгоор асрамжлуулан, хамгаалуулах эрхтэйг НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭК)-д нэгдсэн улс орнууд хүлээн зөвшөөрсөн. НҮБ-ын ХЭК-д хүүхдийн хамгаалуулах эрхтэй холбоотой дараах тусгай заалтууд байдаг (НҮБ, 1989). Үүнд:

- Хүүхэд бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалуулах тухай (19 дүгээр зүйл);
- Гэр бүлтэйгээ амьдрах боломжгүй хүүхдийг төрөөс асрамжлан хамгаалах (20 дугаар зүйл);
- Үрчлэгдсэн хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих (21 дүгээр зүйл);
- Дүрвэгчийн хүүхдийг бусад хүүхэдтэй адил тэгш авч үзэх (22 дугаар зүйл);
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцсэн халамж үйлчилгээ үзүүлэх (23 дугаар зүйл);

- Хүүхдийг аюултай мансууруулах бодис хэрэглэхээс хамгаалах (33 дугаар зүйл);
- Хүүхдийг бэлгийн замаар ашиглах, мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах (34 дүгээр зүйл);
- Хүүхдийг хулгайлах, худалдахаас хамгаалах (35 дугаар зүйл); хүүхдийг мөлжлөгөөс хамгаалах (36 дугаар зүйл);
- Эрх чөлөөгөө хасуулсан хүүхэдтэй хэрцгий хүнлэг бусаар харьцахыг цээрлэх (37 дугаар зүйл);
- Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнөөс хамгаалах (38 дугаар зүйл);
- Хохирогч хүүхдийг нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх тухай (39 дүгээр зүйл);
- Шударга хууль эрх зүйн орчны тухай (40 дүгээр зүйл);
- Хүүхдэд ээлтэй хуулийг мөрдөх тухай (41 дүгээр зүйл);
- Хүн бүр хүүхдийн эрхийг мэддэг байх тухай (40 дүгээр зүйл) тус тус заасан (НҮБ, 1989).

Дээрх дурдсан ХЭК-ын хамгаалуулах эрхтэй холбоотой заалтуудаас гадна хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалахтай холбоотой заалтуудыг, энэ чиглэлээрх бусад НҮБ-ын конвенц, протоколуудтай хамтатган бичвэл дараах жагсаалт үүснэ. Үүнд:

1. НҮБ-ын ХЭК-ийн 19-р зүйлд заасан хүүхэд бэлгийн хүчирхийллээс хамгаалагдах эрхтэй тухай заасан.
2. НҮБ-ын ХЭК-ийг хэрэгжүүлэх, ялангуяа 1, 11, 21, 33, 34, 35, 36 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхийн тулд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлах явдлаас хүүхдийг хамгаалах тухай ХЭК-д оруулах нэмэлт прокотолд тусгасан (НҮБ, 1989).
3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, нэн даруй устгах тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182-р конвенцод хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт багтаан нэн даруй устгах тухай заасан.
4. Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой холбоотой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенцод Монгол Улс 1968 онд нэгдэн орсон.
5. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцод Монгол Улс 2000 онд нэгдэн орсон.
6. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” нэмэлт протоколд Монгол Улс 2008 онд нэгдэн орсон (УИХ, 2008).

Охид, эмэгтэйчүүдтэй холбоотой НҮБ-ын конвенцод Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц багтана. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 сарын 18-ны өдрийн тогтоолоор Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн баталж 1981 оны 9 сарын 3-нд хүчин төгөлдөр болгосон. Монгол улс 1979 оны 7 сарын 10-д гарын үсэг зурж, 1981 оны 5 сарын 14-нд баталсан (УИХ, 1981). НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 сарын 15-ны өдөр “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай 2000 оны 11 сарын 15-ны өдрийн протоколд Монгол улс нэгдэн орсныг Монгол Улсын их хурал 2008 оны 5 сарын 16-нд соёрхон баталсан (УИХ, 2000).

Түүнээс гадна 1995 онд Бээжинд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын үед охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай тунхаглал баталсан, охидын эрхийг тусгайлан авч үзсэн анхны тунхаглал байсан юм. Охид эмэгтэйчүүдийн эрхийг хангах талаар олон улсын

хүчин чармайлтууд гарсаар байсан хэдий ч дэлхийн өнцөг булан бүрд амьдарч буй охидын эрх зөрчигдөж, тэдэнд тулгарах өвөрмөц сорилт бэрхшээлүүд нь Олон улсын охидын өдрийг НҮБ-аас зарлахад хүргэсэн. 2011 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 66/170 тоот шийдвэрээр жил бүрийн 10 дугаар сарын 11-ны өдрийг “Охин хүүхдийн олон улсын өдөр” болгон зарласан (UN Women, 2022). Энэ өдрийг дэлхийн өнцөг булан бүрд охидын эрхийг хамгаалах, тэднийг хүчирхэг болгохыг дэмжих, тэдэнд тулгарч буй өвөрмөц сорилт бэрхшээлүүдэд олон нийтийн анхаарлыг хандуулахад зориулдаг.

Монгол Улс эдгээр конвенц, протоколд нэгдэж хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл болон мөлжлөгийг гэмт хэрэгт тооцон, хохирогч хүүхдийг хамгаалан, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн. Монгол Улсын хууль тогтоомжид тодруулбал Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хуулиудад хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг гэмт хэрэгт тооцох, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ноогдуулах ял шийтгэлийг тодорхой заасан байдаг.

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуульд хүчирхийлэлд өртсөн ба өртөх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хамгаалах, хариу арга хэмжээ авах тухай зааж, хуулийн хэрэгжилтийг хангах 40 гаруй журам батлагдан мөрдөгдөж байна. Хамгийн сүүлд гарсан хоёр журмын нэг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-нд баталсан А/228 тоот журам. Энэ журамд Хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай тусламжийн, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилсан сэргийлэх гэсэн гурван түвшинд хүргэхээр тусгасан (ХНХЯ, 2021). Хүүхэд хамгааллын үйлчилгээнд дэвшил авчрах дараагийн нэг журам нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрээс нь хамаарч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хугацаа, санхүүжилтийг зохицуулах журам. Энэ журам нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдаж, хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын тухай тодорхой заасан (ХНХЯ, ХЗДХЯ, 2022).

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12, 13-р бүлэгт тусгасан. Энэ төрлийн гэмт хэрэгт хүчиндэх, бэлгийн дүр хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүн худалдаалах зэрэг гэмт хэргүүд багтана. Гэхдээ 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг тусгайлан бүлэг болгон хуульчилсан нь ололттой хэдий ч хүчиндэх, бэлгийн дүр хүслээ ёс бусаар хангах, гэмт хэргийн шинжийг (бүрэлдэхүүнгүй) оновчгүй тодорхой бус байдлаар хуульчилсан хэрэглэхэд ойлгомжгүй байдал бий болгох, зүйлчлэхэд хүндрэл учруулж байна гэж судлаачид дүгнэсэн (Т.Оюунчимэг, Ж.Болдбаатар, М.Эрдэнэбаяр, Ч.Нямсүрэн, Б.Мөнхдорж, бусад., 2019, хууд.45). Мөн энэ гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон тохиолдолд “Хохирогч, насанд хүрээгүйн улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй” тохиолдол хэмээн үзэж хэргийг хэрэгсэхгүй болгохгүйгээр шүүхээр шийдвэрлүүлж байх хуулийн заалтыг хатуу баримтлах ёстой гэж тэд үзсэн (Т.Оюунчимэг, Ж.Болдбаатар, М.Эрдэнэбаяр, Ч.Нямсүрэн, Б.Мөнхдорж, бусад., 2019, хууд.45). 2022 оны Улсын Их Хурлын хаврын чуулганаар 2015 оны Эрүүгийн хуулийг шинэчлэх хэлэлцүүлэг явагдаж байгаа тул дээр дурдсан тодорхой бус заалтууд өөрчлөх саналуудыг холбогдох байгууллагууд гаргаад байна.

2.2

ХҮҮХДИЙН ХАМГААЛАГДАХ ЭРХ ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Дэлхийн 96 орныг хамарсан хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай судалгааг хийсэн С. Хэллис, Ж. Мэрси, А. Амоби нар тэдний судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн тал хувь буюу нэг тэрбум гаруй хүүхэд сэтгэл санаа, бие махбод, бэлгийн хүчирхийлэлд судалгаа авахын өмнөх жилийн хугацаанд өртсөн болохыг илрүүлжээ (WHO, 2016, р. 12). Тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн хүйсээр нь авч үзвэл, охидын 18 хувь, хөвгүүдийн 8 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Түүнчлэн 15-аас 19 насны гурван охин тутмын нэг нь нөхөр эсхүл хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн сэтгэл санааны, бие махбодын, бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. Амиа хорлосон өсвөр насныхны 80 гаруй хувийг хөвгүүд эзэлж байгаа бөгөөд тэд өөрийн амиа егүүтгэх эсхүл хэн нэгэн түүнийг амиа хорлоход хүргэх тохиолдол их байдаг тухай олон улсын судлаачид мэдээлж байна (WHO, 2016, р.12).

Монгол Улсын хувьд бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж энэ гэмт хэрэгт насанд хүрээгүй хүн өртөх явдал нэмэгдэж байгаа тухай судлаачид болон албаны хүмүүс мэдээлж байна. 2018 онд үндэсний хэмжээний судалгаанд хамрагдсан 7319 эмэгтэйн арван эмэгтэй тутмын нэг буюу 10.7 хувь нь хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлсэн бөгөөд хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн гурван эмэгтэй тутмын нэг нь тэдний гэр бүлийн бусад гишүүн, 19 хувь нь найз нөхөд, 18.7 хувь нь танихгүй хүмүүс хүчирхийлсэн гэж хариулжээ (ҮСХ, 2018, хууд. 79). Түүнчлэн цагдаагийн байгууллагад сүүлийн гурван жил [2019 онд бичигдсэн тайлан]-д 947 буюу ойролцоогоор өдөрт 1 бэлгийн хүчирхийлэл шалгагдаж, хохирогчдын 80 хувь нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд, 46.8 хувь нь 8-17 насны охид байсан бөгөөд тэдний ихэнх нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчид байжээ (Оюунчимэг, бусад., 2019, хууд.5)

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тархалтын түвшин өндөр гэсэн албан ёсны статистик мэдээллээс гадна мэдээлэгдэхгүй, далд үлдэх тохиолдлууд их байдаг тухай олон улсын судалгаа шинжилгээний тайланд дурдагддаг. Тухайлбал мэдээлэгдээгүй далд байгаа хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тохиолдлын тоо албан ёсны тохиолдлын тооноос 30 дахин, бие махбодын хүчирхийллийн тохиолдлын тоо 75 дахин өндөр болохыг олон улсын судлаачид тогтоосон (WHO, 2016, р. 12). Түүнчлэн хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээллийн дагуу үзүүлэх үйлчилгээ муу, хүчирхийллийн хохирогч хүүхдэд итгэхгүй байх, хүчирхийллийн улмаас хүүхдэд үүссэн сэтгэл зүйн гэмтэл бэртлийг анхаарч үзэхгүй, үйлчилгээ үзүүлэх явцдаа хүүхдийг дахин сэтгэл зүйн хувьд гэмтээх, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд, түүний гэр бүл, орон нутгийн онцлогт нийцүүлэн хүргэх боловсон хүчний мэдлэг туршлага дутмаг, байгууллага, орон нутгийн чадавх сул зэрэг олон асуудлууд байсаар байна.

Гэхдээ хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийллийн хохирогч хүүхдийг хамгаалах олон улсын хийгээд үндэсний амлалт, санал санаачилгууд нэмэгдэж, хүүхэд хамгааллын салбарын болон салбар хоорондын хамтын ажиллагаа өргөжсөөр байна. Тухайлбал 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтуудын 16.2-т “Хүүхдийн эсрэг хүчирхийллийн

бүх хэлбэр, мөлжлөг, хүн худалдаалах явдал, хүүхдийг хэрцгий харгислах явдлыг устгана” гэж заасан (WHO, 2020). Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж болохыг дэлхийн олон баримт, жишээ харуулж байна (WHO, 2020).


Тиймээс хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хүчирхийллийн хохирогч, даван туулагч хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд баримтлах олон улсын хийгээд үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хамгааллын тогтолцооны өргөн хүрээнд харж, хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийн талаарх ойлголт мэдлэгээ нэмэгдүүлж, бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог ханган ажиллах хэрэгцээ шаардлага байсаар байна. Иймд хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээний бүрэлдэхүүн хэсгүүдийн тухай дараагийн онолын хэсэгт танилцуулах болно.

2.3

ХҮҮХДИЙН ХАМГААЛАГДАХ ЭРХ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ

Хүүхэд хамгааллын тогтолцоо нь нийгмийн тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг. Тогтолцооны онол нь байгалийн шинжлэх ухаанд анх нэвтэрсэн хэдий ч уг онолыг нийгмийн шинжлэх ухаанд юмс үзэгдлийн зүй тогтол, хөдлөл зүйг тогтолцооны хүрээнд харж тайлбарлахад өргөн ашигладаг. Энэ онолоор аливаа нэг тогтолцоо/систем нь дэд систем болох бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваагдах бөгөөд өөрөө бас том тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болно гэж үздэг. Хүүхэд хамгааллын тогтолцоо нь нийгмийн хамгааллын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг нь болохын сацуу дотроо хэд хэдэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.

Зураг 2. Хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд



Зураг 1-д Хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийн харуулав. Эдгээр дэд хэсгүүдийн тоонд хүүхэд хамгаалах хууль эрх зүйн орчин, хүүхэд хамгааллын салбарыг удирдан чиглүүлэх, үйлчилгээ хүргэх эрх бүхий байгууллага, түүний бүтэц, бүрэлдэхүүн, хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сүлжээ, хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ, чадварлаг бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин, хангалттай нөөц хөрөнгө, зөв хуваарилалт, хүчирхийллийг үл тэвчдэг олон нийт, тэр дунд хүүхдийг ойлгож хамгаалдаг гэр бүл, түүнтэй адилтгах орчин, хамгаалагдах ёстойгоо мэддэг, тусламж хүсэж чаддаг хүчирхэг хүүхэд гэсэн бүрэлдэхүүн хэсгүүд багтана (А.Батхишиг, 2011; 2021; 2022; SCUK, 2010; Calder & SCUK, 2019). Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд тус бүртээ өөрийн гэсэн хил хязгаартай ч тэр хил хязгаараараа бусад бүрэлдэхүүн хэсэгтэй холбогдох, мэдээлэл бусад нөөцөө солилцоно. Зарим бүрэлдэхүүн хэсэг хоорондоо нээлттэй харилцаатай байхад зарим дэд хэсгүүд бусад бүрэлдэхүүн хэсэгтэйгээ холбогдохгүй, хоорондын харилцаа холбоо сул, хаалттай хил хязгаартай байна.

Тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлт нь том тогтолцоондоо буюу бусад бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлөх эсэх нь тухайн тогтолцооны бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн бие даасан шинж, гаднын өөрчлөлтөд зохицох уян хатан чанараас хамаарна. Тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийн бие даасан шинж сул, тогтвортой шинж муу бол нэг бүрэлдэхүүн хэсэгт гарч буй өөрчлөлт бусад бүрэлдэхүүн хэсэгтэй хүчтэй нөлөөлнө гэж үздэг. Энэ тайлбараар бол хүүхэд хамгааллын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэгт гарсан өөрчлөлт нь тухайлбал хууль эрх зүйн орчны өөрчлөлт нь хамгааллын салбарын ажилтан, албан хаагчид, тэдний үйлчилгээ, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийн бааз, хөрөнгө санхүү, олон нийт зэрэг бусад бүрэлдэхүүн хэсгүүддээ тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэсэн үг.

Хүүхэд хамгааллын тогтолцооны хэвийн, тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд бүрэлдэхүүн хэсгүүдийн хооронд мэдээлэл солилцох, тэдний уялдаа холбоог сайжруулах, дэд хэсгүүдийн нөөц хүчийг зөв ашиглах явдал их чухал. Хүүхдийн хамгаалагдах эрх нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд хамаатай.

Хүүхдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах эрхийг хангахын тулд хүүхдийн, түүний гэр бүл, олон нийт, нийгмийн орчны хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх, нөгөө талаас эрсдэлийн хүчин зүйлсийг бууруулах, хамгаалах хүчин зүйлийг бэхжүүлэх мэдлэг, ур чадвартай байх явдал их чухал (А.Батхишиг, 2019). Нийгэм, орон нутаг, хүүхдийн гэр бүл ба түүнтэй адилтгах орчин, хүүхдийн өөрийн хамгаалах хүчин зүйлсийн тоонд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилт сайн байхаас эхлээд, хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй орон нутагт амьдрах, эцэг эх, хамаатан садны дэмжлэг туслалцаа сайн байх, хүүхэд өөртөө итгэлтэй, нийгмийн ур чадвар сайтай байх зэрэг хүүхдийг хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлс багтана. Харин нийгэм, эдийн засаг, жендэрийн тэгш бус байдал, ядуурал, ажилгүйдэл, шилжилт хөдөлгөөн их, гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эхийн хүмүүжил, төлөвшил тааруу, хүүхдийн нас, хүйс, зан авир, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогч байх зэрэг нь хүүхдийг хүчирхийлэлд өртөхөд хүргэх эрсдэлт хүчин зүйлс болох юм.

Хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, нийгмийн ажлын үйлчилгээ хүргэх явцад хамгаалах болон эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлсноор хүүхдийн өөрийн биологи, нийгэм сэтгэхүйн онцлогоос эхлээд гэр бүл, амьдарч буй орон нутаг, нийгмийн олон талт хүчин зүйлсэд чиглэсэн тусгай болон ерөнхий интервенцийг хамгааллын үйлчилгээндээ тусгах боломжийг өргөтгөнө.

2.4

ХҮҮХДИЙН ХАМГААЛАГДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Хүүхдийн хамгаалагдах эрхийг хангахад хүүхэд хамгааллын тогтолцооны бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн үүрэг, үйл ажиллагаа чухал. Гэхдээ энэ сэдвийн хүрээнд хүүхдийн хамгаалагдах эрхийг хангах үр дүнтэй хууль тогтоомж, ялангуяа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдийг хамгаалах хууль тогтоомжийн талаар авч үзнэ. ДЭМБ-аас гаргасан Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх долоон стратегийг хэрэгжүүлэх арга зам сэдэвт Inspire гарын авлагад зааснаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг тодорхойлж хориглосон сайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь хүчирхийллийг эцэслэх үр дүнтэй хүчин чармайлт гэж үздэг (WHO, 2018, р. 32). Хууль дангаараа хүчирхийллийг бууруулахгүй ч гэсэн хуулийг үр дүнтэй сахин хэрэгжүүлж чадвал хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэхэд их хувь нэмэр оруулна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, хүчирхийллийн хохирогч хүүхдийг хамгаалахад хууль тогтоомжийн оновчтой зохицуулалт, хүүхдэд ээлтэй шударга ёсны асуудлыг хөндөнө. Хүүхдэд ээлтэй шударга ёс гэдэг нь:

- Хүртээмжтэй, шуурхай, анхааралтай байх ёстой.
- Хүүхдийн нас, хүйсэд тохирсон, хүүхдийн хэрэгцээг анхаарсан
- Хүүхдийн дараах эрхүүдийг хүндэтгэхийг хэлнэ. Үүнд:
 - Шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэх
 - Шүүх ажиллагаанд идэвхтэй оролцох
 - Хувийн болон гэр бүлийн амьдралтай байх
 - Хувийн орон зай болон хувийн нууцтай байх
 - Нэр төрөө, өөрийн мөн чанараа хамгаалах явдал багтана.

Хүүхдийн хамгаалагдах эрхийг хангах энэ сэдвийн үндсэн ойлголтын хэсэгт дурдсан олон улсын хийгээд үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт үйлдлүүдийг тодорхойлж, гэмт хэрэгт тооцон, яллах механизмыг бий болгохын сацуу хохирогч хүүхдийг хамгаалах дэмжлэгийг бий болгоно. Ингэж хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн хууль тогтоомж, түүний хэрэгжилтэд анхаарснаар хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөгийг хүлээн зөвшөөрөх байдлыг бууруулах, асуудлыг мэдээлэх, тусламж хүсэхийг нэмэгдүүлэх, мөрдөн байцаах болон хэрэгтнийг яллах явдал нэмэгдэх, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг буурах зэрэг үр дүн гарна гэж үздэг (WHO, 2018, р. 39).

ДЭМБ-ын танилцуулсан “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх долоон стратегийг хэрэгжүүлэх” арга зам сэдэвт Inspire гарын авлагад хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг гэмт хэрэгт тооцсон хууль тогтоомжуудыг эргэн харж сайжруулахад эрх зүйн; тогтолцоо, захиргааны; орчны гэсэн гурван бүлэг саад бэрхшээл тулгардаг болохыг дурдсан байдаг. Энэ гурван төрлийн саад бэрхшээлийг хэрхэн бууруулах талаар Inspire хөтөлбөрт танилцуулсныг Шигтгээ 3-т танилцуулж байна (WHO, 2018, р. 43-44).



Шигтгээ 2. Бэлгийн хүчирхийлэл болон мөлжлөгөөс хүүхдийн хамгаалагдах эрхийг хангахад тулгарч буй саад бэрхшээлийг бууруулах арга замууд

Тулгарч буй саад бэрхшээл	Саад бэрхшээлийг бууруулах боломж, арга замууд
Эрх зүйн саад бэрхшээл: Хуулийн үг хэллэг нь цогцоор хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах	<ul style="list-style-type: none"> – Хориглосон үйлдлүүдийг нарийвчлан тодорхойлох, энэ хориглосон заалт нь эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн аль алинд ижил үйлчилдэг байх – Бүх хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, асуудлыг шийдвэрлэх – 0-18 насны бүх хүүхэд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хуулиар хамгаалагдсан байх – Хохирогч нь албан ёсоор гомдол мэдүүлээгүй байсан ч хүүхдийн эсрэг хүчирхийллийн кейс / тохиолдолд шууд мөрдөн байцаалт, шүүх прокурорын үйл ажиллагааг эхлүүлэх
Тогтолцоо, захиргааны саад бэрхшээл: Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг таних, мэдээлэх, мөрдөн байцаах болон яллах үйл явц саатах, цоорхой байх, эсхүл үндэстэн дамнасан болон цахим орчинд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл болон мөлжлөгийг шийдвэрлэхэд тухайлсан бэрхшээл гарах зэрэг багтана.	<ul style="list-style-type: none"> – Салбар хоорондын болон олон улсын хамтын ажиллагааны албан ёсны механизмыг бий болгох – Зохиц [шаардлагатай] салбарт нь мөрдөн байцаалт, прокурорын үйл явцын хүрээнд тодорхой үүрэг хариуцлагыг оноож өгөх – Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдэд үйлчилгээ хүргэх тусгай хэлтэс, тасаг, нарийн мэргэжлийн ажилтнуудад сургалт явуулж, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд шууд үйлчилгээ хүргэх анхан шатны бэлтгэгдсэн ажилтан байгаа эсэхэд хяналт тавих – Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд үзүүлэх нийгэм, эрүүл мэнд, эрх зүйн тусламж, үйлчилгээ хүргэх тогтолцоог бэхжүүлэх – Бэлгийн хүчирхийлэлд өртсөн бага насны болон өсвөр насны хүүхдэд шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хүргэх
Орчны саад бэрхшээл: Бэлгийн хүчирхийлэл болон мөлжлөгийн хохирогчийг хэрхэн яаж харахад нөлөөлөх нийгэм, жендэрийн хэм хэмжээ	<ul style="list-style-type: none"> – Хүүхдэд ээлтэй шударга ёсыг тогтооход тулгарч буй тодорхой асуудал, эмзэг байдлыг шийдвэрлэх – Бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх – Хүчирхийллийг дэмжсэн, хүлээн зөвшөөрсөн жендэр болон нийгмийн хэм хэмжээг өөрчлөх – Хүчирхийлэлтэй холбоотой сөрөг ойлголтыг багасгах тусламж хүсэхэд дэмжлэг үзүүлэх

Шигтгээ 3-т үзүүлснээр хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгтэй тэмцэх хууль тогтоомжийн хүрээнд тулгарч байгаа бэрхшээлийг эрх зүйн; тогтолцоо, захиргааны; орчны бэрхшээлүүд гэж гурван ангилсан байна. Эдгээр бэрхшээлийг бууруулахад зөвхөн хууль тогтоомж, хууль сахиулах хүрээнд тулгарч буй бэрхшээлийг арилгахаас гадна, хууль сахиулах салбарынхантай хамтран ажилладаг бусад салбарын ажилтан албан хаагчдын мэдлэг үр чадвар, тэдний үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах, мөн бэлгийн хүчирхийлэл, түүнээс урьдчилан сэргийлэх тухай олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хүчирхийллийг үл тэвчих олон нийтийн хандлагыг өөрчлөх зэрэг арга замууд багтаж байна.

Монгол Улсын хувьд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийг нийгмийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу хэрхэн авах талаар Хүснэгт 1 ба Хүснэгт 2-т танилцуулж байна.

Хүснэгт 1. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг хүлээн авах эрх бүхий байгууллага, албан тушаалтан

Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээх авах байгууллага, албан тушаалтан	Монгол Улсын хуулийн холбогдох заалтууд
<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн тусламжийн 108 утас, Цагдаагийн 102 утас, 107 утас, Түргэн тусламжийн 103 утас - Баг, хорооны Засаг дарга, Тамгын газар, хамтарсан багийн багийн гишүүд; нийгмийн ажилтан, хэсгийн цагдаа, эмч, хэсгийн ахлагч - Сум, дүүрэг, нийслэл, үндэсний Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс - Сургууль, эмнэлгийн ажилтан албан хаагч - Хүүхдийн төлөө ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчид 	<p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.1-д Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна.</p> <p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.2-т Энэ зүйлд заасан мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулж болно.</p> <p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.2-т Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ.</p> <p>Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 19.2-т Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, сум, баг, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан нь хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд хүсэлт, шаардлага гаргаж болно</p>

Сургалтын байгууллагын багш, ажилтан албан хаагчид эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Монгол Улсын Хүүхдийн эрхийн хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ. Хүүхдийн эрхийн хуулиар үүрэг хүлээсэн оролцогч гэдэгт Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, цагдаагийн байгууллага, хамтарсан баг, хүүхдийн эрхийн улсын байцаагч хамаарна.

Хүснэгт 2. Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэргийг илрүүлэх, шалгах байгууллага, эрх бүхий албан тушаалтан


Хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, шалгах байгууллага, эрх бүхий албан тушаалтан	Монгол Улсын хуулийн холбогдох заалтууд
<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн 108 тусламжийн утас - Баг, сум, хорооны хамтарсан баг - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн түр хамгаалах байрын ажилтан, албан хаагч - Хүүхдийн эрхийн улсын байцаагч - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн дарга 	<p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.3.-д Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх бөгөөд тухайн асуудлыг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад заавал мэдэгдэнэ.</p> <p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.4.-д энэ [11-р] зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж, холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлнэ.</p> <p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.5.-д заасны дагуу хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.</p> <p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.6-д заасны дагуу хүүхдийг түр тусгаарлах шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нийгмийн ажилтан, албан тушаалтан хуульд заасан боломжит арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүн, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.</p> <p>Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.7-д заасны дагуу хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.</p> <p>Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.4.-д зааснаар улсын байцаагчийн эрх бүхий ажилтан нь хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулна.</p>

Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэргийн тухай мэдээллийг хүлээн авах , илрүүлэх, шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд, тэдний эрх үүргийг хуульчилсан хуулийн заалтуудыг Хүснэгт 1 ба 2-т танилцууллаа. (УИХ, 2016 а; УИХ, 2016 б; УИХ, 2017;).

Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэргийг хүүхдийн эрхийн улсын байцаагч дараах шат дарааллаар шалгаж шийдвэрлэнэ.

Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Монгол Улсын Зөрчил маргааныг шалган шийдвэрлэх тухай хуулийн зургаадугаар бүлгийн 6.2-р зүйлд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэлийн дагуу гомдол мэдээллийг хүлээн авна (Г.Оюунболд, П.Намуун, 2021, хууд.20).

Хүүхдийн эрхийн байцаагч нь Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 -р зүйлийн хоёр дахь хэсэгт заасны дагуу ажлын тав хоног дотор гомдол, мэдээллийг шалгаж, дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана.



Эх сурвалж: Г.Оюунболд, П.Намуун, 2021, хууд.20

Хүүхдийн эрхийн байцаагч [эрх бүхий албан тушаалтан] нь гомдол мэдээллийг хүлээн аваад уг гомдол, мэдээлэл гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй эсэхийг тогтоож, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллын дагуу Хүүхдийн эрхийн улсын байцаагчид харьяалах хэрэг мөн эсэхэд дүгнэлт хийнэ. Уг дүгнэлтэд гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, эсхүл зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан нь гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх тогтоол үйлдэж прокурорт уламжилснаар (Г.Оюунболд, П.Намуун, 2021, хууд.20) тухайн асуудал шүүхийн байгууллагаар шийдэгдэх үйл явц эхэлнэ.

2.5

ХҮҮХДИЙН ХАМГААЛАГДАХ ЭРХИЙН ТАЛААР БУСАД УЛС ОРНЫ САЙН ТУРШЛАГА

Доминикан улсын жишээ

Ерөнхий шүүгчийн ажлын алба, аялал жуулчлалын цагдаа, зоогийн газар, буудлын үндэсний холбоо, иргэний нийгмийн байгууллагууд хамтран Доминиканы Бүгд Найрамдах улсын аялал жуулчлалын салбарт тохиолдох хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг хангах чадварыг нэмэгдүүлж чаджээ. Дээр дурдсан Доминиканы шүүх, цагдаа, нийтийн хоол, иргэний нийгмийн салбарынхан хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөгийн тохиолдлыг таньж мэдэх, мэдээлэх зэрэг сэдвээр сургалтад хамрагджээ. “Ямар ч шалтаг хэрэггүй” нэртэй олон нийтийн компанит ажил зохион байгуулж, олон нийтийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдлэгийг нэмэгдүүлж, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэхийг уриалсан. Доминикан улс нь цахим орчин дахь бэлгийн мөлжлөгийн хэргийг мөрдөн байцаах чадавхаа бэхжүүлэн, улмаар мөрдөн байцаах тусгай хэлтсийг байгуулан ажиллаж байна (WHO, 2018).

Монгол улсын жишээ

Хүүхдийг Ивээх Сан (ХИС)-гийн “Хүүхэд хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл 2015 оноос 2018 онд Жайка Олон улсын байгууллагын санхүүжилтээр Улаанбаатар хотын гурван дүүрэг, Архангай аймгийн 3 суманд хэрэгжсэн. Энэ төсөл нь Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг бэхжүүлэх чиглэлээр өргөн хүрээнд хувь нэмэр оруулсныг дараах тоо баримт, сайн жишээ харуулж байна. Үүнд:

Нэгдүгээрт, 2016 онд батлагдсан Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийг боловсруулах ажлын хэсэг, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг, мөн Хүүхэд хамгаалах тухай хуулийг дагалдан гарах журмуудыг боловсруулах ажлын хэсэгт тус сангийн мэргэжилтнүүд орж ажиллан хүүхэд хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болоход хувь нэмрээ оруулсан (Г.Түмэннаст, бусад., 2018);

Хоёрдугаарт, төсөлд хамрагдсан хороо/багийн засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаа, эмч, хэсгийн ахлагч, сургуулийн нийгмийн ажилтан зэрэг салбар салбарын анхан шатанд ажиллаж буй ажилтнуудын төлөөллөөс бүрдсэн хамтарсан багийн гишүүдийн хамтын ажиллагаа, үүрэг даалгаврын биелүүлэлт төсөлд хамрагдаагүй хяналтын багийнхаас дээгүүр үзүүлэлттэй болох нь статистикийн ач холбогдлын төвшинд байсныг тус төслийн үнэлгээний тайланд дурдсан байна (Г.Түмэннаст, бусад., 2018, хууд.20);

Гуравдугаарт, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд, хамтарсан багийн гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хүүхдийн хүмүүжлийн эерэг аргууд, хамтарсан багаар ажиллах аргазүй, стресс менежмент, кейсийг хэрхэн бүртгэх, кейс дээр хэрхэн ажиллах чиглэлээр сургалт зөвлөгөөг өгөн хүүхэд хамгааллын чадварлаг ажиллах хүч бэлтгэхэд хувь нэмэр оруулсан (Г.Түмэннаст, бусад., 2018, хууд.26);

Дөрөвдүгээрт, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхдийн илрүүлэлт нэмэгдэж, мэдээллийг ихэвчлэн хэсгийн ахлагч нар, хүүхдийн тусламжийн 108 утас, цагдаагийн дуудлага, оршин суугчид зэрэг эх сурвалжаас, ялангуяа төрийн байгууллагуудтай нягт хамтран хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулахад ахиц дэвшил гарсан байна (Г.Түмэннаст, бусад., 2018, хууд.33);

Тавдугаарт, ХИС-гийн төслийн хүрээнд хамтарсан багийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний маягтуудыг боловсруулж, тэдгээр маягтууд тухайн үеийн нэршлээр Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын 2016 оны 4 сарын 13-ны өдрийн А/42 дугаар тушаалаар батлагдсан. Энэ маягтууд нь хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхэд хүлээн авах, эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, кейс төлөвлөгөө, аюулгүй байдлын төлөвлөгөө, ярилцлагын тэмдэглэл, үйл явцын тэмдэглэл, холбон зуучлах маягт, кейс шилжүүлэх маягт, кейс хаах, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын тооцооны маягтууд байлаа. Эдгээр маягтуудыг хүүхэд хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлснээрээ хүүхэд хамгааллын үйлчилгээний бүртгэл мэдээлэл, баримтжуулалтыг шинэ шатанд гаргасан юм;

Зургаадугаарт, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хүүхэд, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ХИС-гийн Хүүхэд хамгааллын арга зүйн төв нь 2016-2017 онд 14 удаагийн нөлөөллийн ажлыг нэвтрүүлэг, мэдээлэл сурталчилгаа, сургалт, болон тэмцээн хэлбэрээр зохион байгуулж, нийт 30,000 гаруй иргэн эдгээр үйл ажиллагаанд нь хамрагдсаныг тус төвийн тайланд дурджээ (Г.Түмэннаст, et al., 2018, хууд. 14).

ХИС-гийн “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хэрэгжилт нь Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоонд олон эерэг өөрчлөлтийг авчирсан.



Мэдлэг шалгах асуултууд

1. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын ялгааг тайлбарлана уу.
2. НҮБ-ын ХЭК-д хүүхдийн хамгаалуулах эрхтэй холбоотой ямар ямар заалтууд байдаг вэ?
3. Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийг хүлээж авах талаар Монгол Улсын ямар хуульд заасан байдаг вэ?
4. Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэргийг ямар шат дарааллаар шалган шийдвэрлэдэг вэ?
5. Хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг нэрлэж, тэдгээрийн хоорондын холбоог тайлбарлана уу.

ГУРАВ

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

- 3.1 Хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжүүлэх арга замын талаарх ойлголт
- 3.2 Сэдвийн ач холбогдол
- 3.3 Онолын үндэслэл
- 3.4 Хүүхэд хамгааллын бодлогын бусад улс орны сайн туршлага

3.1

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Хүүхэд хамгааллын бодлогын тухайд

Хүүхэд хамгааллын бодлогыг энгийнээр хэлбэл хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ямар нэг хор хөнөөл үзүүлэхээс хамгаалахын тулд байгууллагын зүгээс юу хийх ёстойгоо тодорхой заасан баримт бичиг юм гэж Австралийн сайн дурын байгууллагын Хүүхэд хамгааллын бодлогод заасан байдаг (Australian Volunteers International, n.d). Энэ баримт бичиг нь байгууллагын бүх ажилтан, албан хаагч, сайн дурын ажилтан нарт зориулсан хүүхдийн аюулгүй байдлыг хангах, байгууллага дээрээ хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах зорилготой дүрэм, заавар болно.

Эцэг эх, асран хамгаалагчийн оронд богино эсхүл урт хугацаагаар хүүхдийг асран хамгаалдаг, хүүхэдтэй ажилладаг байгууллага нь байгууллагынхаа асрамж халамжид байгаа, хамтран ажилладаг, харьцдаг хүүхэд бүрийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байгууллагын дүрэм, зааврыг хүүхэд хамгааллын бодлого, дүрэм заавартаа тусгана. Өөрөөр хэлбэл, байгууллагынхаа онцлогт тохирсон хүүхэд хамгаалах дүрэм, хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх заавар, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх алхам-шат дараалал, ажилтан албан хаагч, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдэд зориулсан сургалт, мэдээлэл, түүнд тавигдах шаардлага зэргийг байгууллагынхаа хүүхэд хамгааллын бодлогод багтаана.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд 2000 оны эхэн үеэс хүүхэд хамгааллын бодлогыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Жишээ нь: Хүүхдийг Ивээх Сан нь 2003 оноос үйл ажиллагаандаа хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөж, шинээр ажилд орж буй ажилтан, албан хаагчидтай хийх хөдөлмөрийн гэрээтэй хамт хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулж, дагаж мөрдөх амлалтыг авч гарын үзэг зуруулж ирсэн (ХИС, 2003).

2010 оны үеэс хүүхдийн эрхийн болон сайн дурын олон улсын байгууллагууд үндэсний төрийн ба төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, олон улсын зөвлөх, сайн дурын ажилтныг Монгол Улсад ажиллуулах тохиолдолд хүлээн авагч үндэсний байгууллага нь Хүүхэд хамгааллын бодлоготой, түүнийгээ хэрэгжүүлэх бүтэц, хүний нөөцтэй байх шаардлага тавих болсон. Жишээлбэл: Австралийн сайн дурын хөтөлбөрийн (Australian Volunteers International) шугамаар сайн дурын ажилтан авч ажиллуулах үндэсний ба орон нутгийн байгууллага нь Хүүхэд хамгааллын бодлоготой байж, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллах ажилтантай байх гэсэн шаардлагыг хангаж байж сайн дурын ажилтан авч ажиллуулах эрх нь нээгдэж байна (AVI, nd). Мөн Австралийн сайн дурын байгууллагаас хүүхэд хамгааллын бодлогоо хэрэгжүүлэх чиглэлээр хамтарч ажилладаг байгууллагууддаа чадавхжуулах сургалтыг тогтмол хийж байна.

Монгол Улсын хувьд 2016 оны Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.1 дэх заалтад “Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөж ажиллана” гэж зааснаар сургалтын байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлоготой байх шаардлага хуульчлагдсан. 2017 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн техник, санхүүгийн тусламжаар ЕБС-ийн Хүүхэд хамгааллын бодлогын эх боловсруулагдсан. Энэ баримт бичгийн төслийг сургуулийн нийгмийн ажилтан болон холбогдох байгууллагууд өргөн хүрээнд хэлэлцэж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт (БСШУС)-ын сайдын 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/476 тоот тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого батлагдсан. Энэ бодлогын өмнө “Боловсролын байгууллагын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам” нь БСШУС-ын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/239 тоот тушаалаар хүчин төгөлдөр болсон. Хоёр жилийн дараа нь БСШУС-ын сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Бодлогын баримт бичиг батлах тухай” А/269 тоот тушаалаар “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого” батлагдсан. Ингэж боловсролын салбар болох сургууль цэцэрлэгийн орчинд Хүүхэд хамгааллын бодлоготой байх тухай журамласан.

Харин Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл (ХТҮЗ)-ийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоолоор “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”, “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”, “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж”-үүдийг тус тус баталсан (ГБХЗХГ, 2021). Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийн зорилго нь “байгууллага, хуулийн этгээд нь өөрийн ажил үйлчилгээ болон ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэж заасан (ХТҮЗ, 2018). Энэхүү хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг нь өмнө дурдсан олон улсын байгууллагууд болон боловсролын байгууллагын хүүхэд хамгааллын бодлогоос ялгагдах онцлог нь байгууллагын ажилтан, албан хаагчид хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл, сэжиг таамгийг байгууллагынхаа эцэг эхийн зөвлөлд мэдээлж, мэдээлэл хүлээн авсан эцэг эхийн зөвлөл нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийг холбогдох байгууллагад мэдээлж тусламж, дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах ажлыг зохицуулна гэж заасан.

ХТҮЗ-ийн баталсан Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичигт тусгагдсан эцэг эхийн зөвлөлийн бүтэц, үйл ажиллагаа нь олон улсад тогтсон хүүхэд хамгааллын бодлогын нийтлэг жишгээс ялгаатайгаас гадна байгууллагын хамтын хүчин чармайлт, эцэг эхийн оролцоонд ач холбогдол өгч боловсруулагдсан. Энэ ялгаа нь сайн, муу хоёр талтай. Эерэг тал нь ямар ч байгууллага, хамт олон нь эцэг эхийн зөвлөлөө байгуулж, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан байгууллагынхаа ажилтан, албан хаагчдад үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, элдэв хүчирхийллээс хүүхдээ хамгаалахад дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ.

Нөгөөтэйгүүр, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн эцэг эхийн тухай мэдээллийг өөр эцэг эх шүүн тунгааж хэлэлцэхэд тэд хүүхдийн дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг хүүхдийн нэрийн өмнөөс авч хэлэлцэж шүүн тунгаах эсэх нь эргэлзээтэй бөгөөд сайн дурын үндсэн дээр хийгдэх байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа нь хүүхдийн хамгаалагдах эрхийг хангах чиглэлээр тууштай ажиллах уу эсхүл хүүхдийн асуудалд анхаарал хандуулах ерөнхий компани ажил болж хувирах эрсдэлтэй. Ямартаа ч хүүхэд хамгааллын бодлоготой байх, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах, хянах тусгай бүтэц, үйл ажиллагаа байх ёстойг олон улсын, үндэсний болон орон нутгийн хүүхэд хамгааллын бодлогын чиглэлээр

танилцуулсан санал санаачилгууд хүүхэд хамгааллын байгууллага, тэдний хамтран зүтгэгчид ойлгох болсон.

Сүүлийн үед “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого” гэж хүүхэд хамгааллын бодлогын шинэчилсэн хувилбарыг практикт илүү их нэвтрүүлж байна. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого нь хүүхдэд хор хохирол учруулахгүй байх, хүүхдийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн байгууллагын бодлого, практик үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн байгууллагын дүрэм заавар юм. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд үзүүлэх хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг үр дүнтэй асран хамгаалах, хүүхэд залуучууд өөрсдийн хамгийн дээд хэмжээнд үр бүтээлтэй байх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авах зэргийг багтаана гэж үздэг (ХИС, 2022).

Хүснэгт 3-т хүүхэд хамгааллын бодлогын, хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлогын ялгаатай талуудыг бичлээ.

Хүснэгт 3. Хүүхэд хамгааллын болон Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлогын ялгаа

Хүүхэд хамгааллын бодлого	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого
Хүүхдэд ямар нэг хор хөнөөл үзүүлэхээс хамгаалахын тулд байгууллага юу хийх ёстойг тодорхой заасан байгууллагын дүрэм.	Хүүхдэд хор хохирол учруулахгүй байх, хүүхдийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн байгууллагын дүрэм.
Хүүхдэд хор хөнөөл учирсан тохиолдолд хэрхэн хариу арга хэмжээ авахыг заадаг	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь хүүхдийг аливаа хор хөнөөлөөс хэрхэн сэргийлэх талаар заадаг
Хүүхэд хамгаалал бол хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйл явцын нэг хэсэг нь болно.	Хүүхэд залуучуудыг хамгийн үр бүтээлтэй байх боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Хүүхэд хамгаалал бол хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйл явцын нэг хэсэг нь болно. Өөрөөр хэлбэл хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь хүүхдийг аливаа хор хөнөөлөөс сэргийлдэг бол хүүхэд хамгаалал хүүхдэд хор хөнөөл учирсан тохиолдолд хэрхэн хариу арга хэмжээ авахыг заадаг гэж энэ хоёр бодлогын ялгааг тайлбарладаг. Гэхдээ хүүхдэд хор хөнөөл учрах эрсдэлтэй эсхүл хор хөнөөл учирсан тохиолдолд хүүхэд хамгааллын бодлогыг нэн тэргүүнд хэрэгжүүлнэ.

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга замууд

Хүүхэдтэй харьцдаг байгууллага бүр өдөр тутам үйл ажиллагаандаа мөрдөх баримт бичиг бол хүүхэд хамгааллын бодлого. Хүүхэд хамгааллын бодлого гэж хүүхэдтэй харьцаж, хүүхдийн төлөө ажиллах, аливаа байгууллага нь байгууллагын дотоод, гадаад орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх багц арга хэмжээг багтаасан байгууллагын бүх ажилтан, албан хаагчид, тэдэнтэй хамтран ажилладаг хамтрагч, сайн дурын ажилтан нарын дагаж мөрдөх бодлого, дүрэм, заавар” юм.

Энэ тодорхойлолтод зааснаар Хүүхэд хамгааллын бодлогыг хоорондоо нягт холбоотой дараах арга замуудаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын дотоод, гадаад орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах
2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслах зогсоох
3. Хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх
4. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх гэсэн арга замуудаар хэрэгжинэ.

Нэгдүгээр арга замын тухайд байгууллагын дотоод, гадаад орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангахад юуны түрүүнд байгууллагын гадаад ба дотоод орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр өөрийн үнэлгээ хийж, байгууллагын орчинд хүүхдэд хор хөнөөл учруулах, хүчирхийлэл дарамт үүсгэх эрсдэлийн хүчин зүйлс байгаа эсэхийг тандах байгууллагын өөрийн үнэлгээ хийхийг зөвлөдөг. Харин хоёр дахь арга зам болох хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох тухайд хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслах зогсооход хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэжиг таамаг эсхүл хүчирхийлэлд өртсөн байж болох мэдээллийг хүлээх авах, мэдээллийн мөрөөр шуурхай хариу арга хэмжээ авахад байгууллага тодорхой бүтэц, нэгж, багийг байгуулах эсхүл хариуцсан тодорхой албан тушаалтныг томилох шаардлагатай. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хариуцсан нэгж, баг эсхүл албан тушаалтны эрх үүргийг тодорхой зааж өгөх, улмаар мэдээлэгчид ямар нэгэн хор хөнөөл учруулахгүйгээр мэдээлэл хүлээн авах арга хэлбэрийг сонгох, нөгөө талаас мэдээллийн дагуу шуурхай арга хэмжээ авах нарийвчилсан заавар, чиглэлийг боловсруулж, байгууллагын бүх, ажилтан албан хаагч, үйлчлүүлэгчид мэдээлж, ил байрлуулах нь таслан зогсоох гол тактик болдог.

ХХБ-ыг хэрэгжүүлэх гурав дахь арга замын тухайд хүүхдийн эсрэг хүчирхийллээс хохирогчийг хамгаалах, түүнд хүүхэд хамгааллын шуурхай тусламж үзүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ хүргэх, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ багтана. Сүүлийн хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх дөрөв дэх хэлбэрийн арга замд байгууллагын хэмжээнд авч хэрэгжүүлэх олон талт үйл ажиллагаа багтана. Үүнд: нэгдүгээрт, байгууллагын ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрэмд хүүхэдтэй харьцах, ажиллахдаа хэрхэн биеэ авч явах тухай, мөн тухайн дүрмийн заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай заалтууд оруулах; хоёрдугаарт, Шинэ ажилтныг сонгон шалгаруулж ажилд авахдаа тус байгууллага хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчинэ гэсэн агуулгатай ажлын зар тараахаас эхлээд сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага, сонгон шалгаруулах үйл явц, танилцах туршилт, жинхлэх хүртэлх бүх үе шатны хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр тандах, мэдээлэх, сургах зэрэг; гуравдугаарт, Байгууллагын ажилтан албан хаагч, сайн дурын ажилтан, дадлагажигч, хамтран ажиллагч, үйлчлүүлэгч гэх оролцогч талуудад зориулсан шаталсан сургалт, зөвлөгөө, сурталчилгааны ажлыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа багтана.

3.2

СЭДВИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Хүүхэдтэй харьцдаг байгууллагын ажилтан, албан хаагч, сайн дурын ажилтан, хамтран ажилладаг байгууллагын ажилтан гээд байгууллагын үндсэн ба гэрээт, харьяа болон хамтран ажилладаг бүх хүн үйл ажиллагаа, үйлчилгээгээ хүүхдэд аюулгүй, хор хөнөөл учруулахгүй байлгах тухай хэлэлцэж, хүүхэд хамгааллын бодлогын талаар ойлголт мэдлэгтэй байх нь хэд хэдэн ач холбогдолтой (AVI, nd). Үүнд:

1. Хүүхдийг хамгаалах нь бүх улс орон, олон нийтийн өмнө тулгардаг асуудал. Өөрөөр хэлбэл НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдсэн улс орон бүр хүүхдийн эрхийг хамгаалах, ялангуяа хүүхэд бүрийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй. Тиймээс, хүүхэд хамгааллын асуудал бол бүс нутаг, улс орон, олон нийт, байгууллага, гэр бүл, хувь хүн гээд хүн бүхний үүрэг юм.
2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамтыг хаана ч хүлээн зөвшөөрч болохгүй гэдгийг байгууллага, хэлтэс нэгж, ажилтан, албан хаагч, тухайн байгууллагатай хамтран ажиллах

бүх хүн хүлээн зөвшөөрч, хүүхэд хамгаалахын төлөө юу хийх ёстой, юу хийж чадахаа амлаж байгаа нь чухал ач холбогдолтой.

3. Байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлогоо боловсруулж, хэрэгжүүлэх бүтэц, үйл ажиллагааны хүрээг тогтоож, хүүхдийн эсрэг хүчирхийллээс ангид байгууллага байхын төлөө амлалт өгөн, түүнийгээ хэрэгжүүлэхэд байгууллагын бүх түвшний ажилтан, албан хаагчид, хамтран зүтгэгчид, байгууллагын үйл ажиллагааны үр шимийг хүртэгч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч оролцож байгаа нь байгууллагын засаглалыг бэхжүүлэхэд тустай.
4. Эцэст нь хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлж, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих бодлого баримтлан хэрэгжүүлэхийн төлөө амлалт авч хүчин чармайлт гаргаж байгаа нь тухайн байгууллагын нэр хүндийг өргөж, үйлчилгээний цар хүрээг өргөтгөнө.

Тиймээс, хүүхэд хамгааллын бодлогын тухай ойлголт мэдлэгтэй байж, ойлголт мэдлэгээ ашиглаж байгууллагынхаа үйл ажиллагааг хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлээс ангид байлгах, хүүхдийн төлөө бүхий л ажиллагаа нь хүүхдэд хор хөнөөлгүй, тэдний сайн сайхан байдлыг дэмжихэд анхаарахад энэ сэдвийн ач холбогдол оршино.

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга замуудын талаар сайн ойлголт мэдлэгтэй байж, тэдгээр арга замуудыг практик үйл ажиллагаандаа нэвтрүүлж, сайжруулан хөгжүүлж байх нь хүүхэдтэй харьцдаг байгууллагыг хүүхдэд аюулгүй, хүүхдэд ээлтэй байгууллага болоход тусална. Үүний тулд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ өмнө дурдсан дөрвөн үндсэн чиглэлийг хамруулан цогцоор анхаарч системтэй зохион байгуулах шаардлагатай. Ингэж чадвал хэсэгчилсэн явцуу хандлагаас зайлсхийж, хүүхэд хамгааллын асуудлыг байгууллагын түвшинд бүтэн дүр зургаар харж, асуудалд илүү нухацтай хандаж чадна.

3.3

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Хүүхэд хамгааллын бодлого нь байгууллагын түвшинд хэрэгжих дүрэм заавар бөгөөд энэ дүрэм зааврыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүүхэд хамгааллын бодлогоо боловсруулан хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагаа нь тодорхой, хоорондоо уялдаа холбоотой байх явдал чухал.

Орчин үеийн нийгмийн байгууллагад тавигдах рациональ зарчмууд нь хүүхэд хамгааллын бодлого боловсруулан хэрэгжүүлэх бүхий л байгууллагад хамаарна. Вебер нь бюрократ тогтолцоо нь байгууллагын зорилгод хүрэх хамгийн оновчтой, үр дүнтэй хэлбэр гэж тодорхойлсон байдаг. Веберийн тодорхойлсноор үр дүнтэй ажиллах бюрократ тогтолцоотой байгууллага нь байгууллагын хэлтэс, нэгжийн чиг үүрэг мөн ажилтан, албан хаагчдын эрх үүрэг, хариуцлага тодорхой, үйл ажиллагаа нь журам дүрмээр зохицуулагддаг, шаталсан захирах зарчимтай, ажлаа бичгээр тайлагнадаг, байгууллага нь ажилтан албан хаагчдаа сургаж, мэргэшүүлдэг зэрэг шаардлага хангасан байх ёстой. Эдгээр шаардлагыг бүрэн хангаснаараа тухайн байгууллагын хэлтэс, нэгж, ажилтан албан хаагчдын бүтэц, чиг үүрэг нь тодорхой, үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээлэл бүртгэгдэн хянагддаг байж үйл ажиллагаа, үйлчилгээний үр өгөөж, хүртээмж нэмэгдэнэ гэж үздэг. Тиймээс, энэ онолын үзэл баримтлалын

дагуу байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлж, хянаж үнэлэхдээ хэн ямар эрх, үүрэгтэй байх вэ, хүүхэд хамгааллын сэжиг таамаг илрэх эсхүл мэдээлэл хүлээн авах үед хэн, юуг, хэрхэн хийх тухай, улмаар хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хэн, яаж, хэрхэн хянаж, үнэлэх гэх мэт хүүхэд хамгааллын бодлогын оролцогч талуудын үүрэг, оролцоо болон бодлогыг хэрэгжүүлэх үе шат, дарааллыг тодорхой нарийвчлан бодлогодоо тусгах шаардлагатай.

Хүүхэдтэй харьцдаг байгууллага бүр байгууллагынхаа онцлог, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээнээс хамаарч хүүхэд хамгааллын бодлогоо ялгаатай боловсруулдаг. Гэхдээ, ямар ч байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын агуулгад зайлшгүй тусгах хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэг байдаг. Үүнд:

- Зорилго
- Баримтлах зарчим
- Хамрах хүрээ
- Нэр томъёоны тайлбар
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах үйлчилгээ, үйл ажиллагааны дараалал
- Хүүхдийн сайн сайхан байдал, аюулгүй байдлыг дэмжих үйлчилгээ, үйл ажиллагаа (Энэ бүрэлдэхүүн хэсэг нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого гэсэн хүүхэд хамгааллын сүүлийн хувилбарт байдаг)
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх сэжиг, таамаг, мэдээллийн дагуу авах хариу арга хэмжээ
- Нууц хадгалах
- Ёс зүйн дүрэм
- Холбогдох баримт бичиг гэх мэт хэсгүүд бүрэлдэхүүнд багтана.

Хүүхэд хамгааллын бодлогын дээр дурдсан бүрэлдэхүүн хэсгүүдийн агуулгад тухайн байгууллагын онцлогтой холбоотой зарим нэг ялгаатай санаа байхаас гадна хамгааллын бодлогын бүрэлдэхүүн хэсэг бүр нийтлэг санаа агуулдаг. Хүүхэд хамгааллын бодлогын бүрэлдэхүүн хэсэг тус бүрд байх шаардлагатай гол санааг тоймлон Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. ХХБ-ын бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн гол санаа

Но	Бүрэлдэхүүн хэсэг	Гол санаа
1	Зорилго	Хүүхэд хамгааллын бодлогын зорилго нь байгууллагын орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.
2	Баримтлах зарчим	Хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хүндэтгэх, хүүхдийн оролцоог хангах, үл ялгаварлах, эсэн мэнд амьдрах эрхийг хангах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөгийг үл тэвчих, хүүхдийн аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагаа эрхэмлэх гэх мэт зарчмууд байна.
3	Хамрах хүрээ	Тухайн байгууллагын хүүхэдтэй харьцдаг бүх хүнд хамаатай.
4	Нэр томъёоны тайлбар	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд тухайлбал хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл, бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт, хүүхдийн хөдөлмөр, сургууль завсардалт, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн тухай тодорхойлолтууд, хүүхэд хамгааллын үйлчилгээний үе шат, хүрээтэй холбоотой тайлбарыг багтаана.

5	Хүүхэд хамгаалах үйл ажиллагаа, үйлчилгээний дараалал	Хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээний хэлбэрүүд, үйл явцын дараалал, хүүхэдтэй харьцах хүнийг шинээр ажилд авахдаа хэрхэн нягтлах дараалал гэх мэт хүүхдэд аюулгүй үйлчилгээ үзүүлэх үйл явц, шат дарааллыг товч, тодорхой бичиж, бүх хүнд харагдахаар ил байрлуулна гэдгийг мэдэгдэнэ.
6	Хүүхдийг дэмжих, оролцоог хангах үйл ажиллагаа, үйлчилгээний дараалал	Хүүхдийн оролцоо, сайн сайхан байдлыг дэмжсэн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд хамруулах үйл явц, дарааллын тухай мэдээлэл байж болно.
7	Мэдээллийн дагуу хариу арга хэмжээ авах дараалал	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлын сэжиг таамаг, мэдээллийг хүлээн авахаас эхлээд мэдээллийн дагуу шуурхай тусламж, дэмжлэг үзүүлэх, хүчирхийллийн хохирогч хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ хүргэх, хохирогч хүүхэд дахин хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх, байгууллагаар үйлчлүүлж байгаа бүх хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагааны бүх шат дарааллын тухай товч мэдээлэл байна. Хэрэв тухайн байгууллага өөрөө хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэггүй бол хамгааллын үйлчилгээнд хохирогч хүүхдийг хэрхэн аюулгүй, хүүхдэд ээлтэй байдлаар холбон зуучилж, шилжүүлэх тухай мэдээлэл байна.
8	Нууц хадгалах	Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл өгсөн хүүхэд болон насанд хүрсэн хүн болон хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийг тодорхойлох мэдээллийг хуулийн хүрээнд хэрхэн нууцыг хадгалж, хамгаалах тухай тусгана. Хүүхдээс мэдээлэл хүлээн авахдаа хүүхдэд хэрхэн ээлтэй, тэдэнд хор хөнөөл, аюул учруулахгүй байх тухай зайлшгүй тусгана.
9	Ёс зүйн дүрэм	Хүүхэдтэй тулж ажиллах болон хүүхэдтэй харьцах бүх ажилтан албан хаагч, сайн дурын ажилтан, дадлагажигч, хамтран ажилладаг байгууллагын ажилтан албан хаагч зэрэг байгууллагатай холбоотой бүх хүн хүүхэдтэй ажиллах, харьцахдаа баримтлах хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх, дагаж мөрдөөгүй тохиолдолд ёс зүйн хариуцлага хүлээх, магадгүй хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэргийн шинжтэй аливаа үйлдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх гэх мэт асуудлыг дүрэмдээ зааж өгнө.
10	Бусад	Байгууллагын үйл ажиллагааны онцлог нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдалд нөлөөлөх, эсхүл хүүхэд хамгааллын асуудал гарч болох бусад эрсдэлт хүчин зүйлс, тэдгээрийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа, зохицуулалтын тухай тусгана.

Байгууллагын ХХБ-ын баримт бичгийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээр хэсэг тус бүрийн агуулгын гол санааг Хүснэгт 3-т тайлбарлан бичлээ. Хүүхэд хамгааллын бодлого (ХХБ)-ын бүрэлдэхүүн хэсэг тус бүрд тусгасан гол санааны дагуу байгууллага дээрээ хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсхүл хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй тохиолдолд ямар арга хэмжээ авч хэрхэн шийдэх талаар алхам алхмаар нарийвчлан бодож, ХХБ-оо боловсруулан хэрэгжүүлэх нь хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхэд нэн чухал.

ХХБ-ыг хэрэгжүүлэх дараах дөрвөн арга зам тухайлбал 1) байгууллагын дотоод, гадаад орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах; 2) хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох; 3) хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх; 4) хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг багтана. Хэдийгээр эдгээр арга замууд нь хоорондоо холбоотой ч тэдгээрийг хэрэгжүүлэх арга зүй, аргачлал нь ялгаатай.

Байгууллагын дотоод, гадаад орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэхийг тандахад гаднын ямар нэг байгууллага, байцаагчийн хяналт шалгалтаас илүүтэйгээр өөрийн үнэлгээ хийх аргыг ашиглах нь тустай. НҮБ-ын Хүүхдийн сангаас Хүүхэд хамгааллын өөрийн үнэлгээний үлгэрчилсэн загварыг боловсруулж ерөнхий боловсролын сургуулиудад туршсан байдаг (UNICEF, 2012; А.Батхишиг, Булганзаяа, 2019). Өөрийн үнэлгээ хийхдээ дараах зургаан чиглэлээр үнэлгээ хийхийг заасан. Үүнд:

1. Хүүхэд ба байгууллага
2. Бодлого ба дүрэм журам
3. Хүүхдэд хор хөнөөл учрахаас сэргийлэх нь
4. Хэрэгжилт ба сургалт
5. Мэдээлэл ба харилцаа
6. Хяналт ба үнэлгээ

Дээр дурдсан чиглэл тус бүрд тавигдах тусгай шаардлагууд байх бөгөөд тэдгээрийг хийгдсэн, зарим нь хийгдсэн, огт хийгдээгүй гэсэн гурван янзын оноогоор үнэлнэ. Байгууллага бүр өөрийн үнэлгээний загварыг байгууллагынхаа хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах хамгийн наад захын шаардлага, байгууллагынхаа онцлог, үйлчилгээний хэлбэрт нийцүүлэн байгууллагынхаа гадаад ба дотоод орчны хамгаалах ба эрсдэлт хүчин зүйлсийг тандах зорилгоор ашиглаж болно. Өөрийн үнэлгээг байнга хийж, эерэг үр дүн, эсвэл сөрөг үзүүлэлтүүдийг тэмдэглэж дараагийн шатны төлөвлөлтдөө ашиглах нь хүүхэд хамгааллын чиглэлээр хийх байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чухал ач холбогдолтой (НҮБ-ын Хүүхдийн Сан, 2012).

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход юуны түрүүнд хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж юу хэлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг хэрхэн таних тухай ойлголтыг хүүхдийн насанд тохирсон агуулга хэлбэрээр таниулах, мөн насанд хүрэгчид ялангуяа хүүхэдтэй өдөр тутам харьцдаг багш, эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дасгалжуулагч зэрэг хүмүүст өргөн хэмжээнд өгөх явдал их чухал. Ойлголт мэдлэгтэй болсон хүүхэд насанд хүрэгчид хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар сэжиг, таамаг, мэдээлэл өгөх боломжтой бүх хувилбар, арга замуудыг бий болгох нь дараагийн нэг алхам. Мөн мэдээлэл өгсөн хүүхэд, насанд хүрэгчдийг хамгаалах, тэдэнд ямар нэг хор хөнөөл учруулахгүй байхаар мэдээллийг хүлээн авах арга замыг сонгох нь мэдээлэл авах давтамж, хүрээг нэмэгдүүлнэ. Эцэст нь мэдээллийн мөрөөр тухайн байгууллагын хүүхэд хамгааллын асуудал хариуцсан баг, ажилтан албан хаагчид юуг хийх тухай тодорхой заасан дүрэм, журмыг Хүүхэд хамгааллын бодлоготой зэрэгцүүлэн хэрэгжүүлэх явдал чухал.

3.4

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН БУСАД УЛС ОРНЫ САЙН ТУРШЛАГА

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь дэлхийн өнцөг булан бүрд үйл ажиллагаа явуулдаг салбаруудынхаа хөтөлбөр, төслийн бүх оролцогч талуудад Хүүхэд хамгааллын бодлогоо танилцуулж, хамтран ажиллах гэрээнийхээ нэг нөхцөл болгон хоёр тал хүлээн зөвшөөрөх практикийг 2000 оноос хойш хэрэгжүүлж эхэлсэн. Улмаар ХИС-гийн олон улсын эвсэл 2010 онд “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах протокол”-ыг баталж, уг протоколд хүүхдэд ээлтэй байгууллага болохын

хувьд ажилтан бүр мөрдвөл зохих тодорхой стандартуудыг тусгасан (ХИС, 2017, хууд. 1). Хүүхдийг Ивээх Сан гийн гишүүн бүр хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, ёс зүйн дүрэмтэй байна гэж уг протоколд заасан. Тиймээс Японы ХИС 2014 онд ХИС-гийн олон улсын эвслийн боловсруулсан “Хүүхдийн аюулгүй байдлын бодлого”-ыг орчуулж, зарим өөрчлөлт оруулан бодлогыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Энэ бодлогын хүрээнд дараах ерөнхий шаардлагууд болон хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой ёс зүйн дүрмийг дагаж мөрдөж ажиллахыг ХИС-гийн бүх ажилтан, сайн дурын ажилтан, хамтран ажилладаг түншлэгч байгууллага, зөвлөхүүдтэй хийсэн гэрээний нөхцөл нэг болгон тусгадаг. Үүнд:

- ХИС нь хүүхэдтэй ажиллах шаардлага хангасан хүнийг ажилд авах бөгөөд ажилтан сонгон шалгаруулах үйл ажиллагаандаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг бүрэн тусгана.
- Байгууллагатай холбоотой хүн бүр үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлаж, хүүхэдтэй зүй бус харьцах, бэлгийн мөлжлөг [дарамт, хүчирхийлэл] үйлдэх асуудалд зохих арга хэмжээ авах чадвартай байна.
- Байгууллагыг төлөөлж буй хүн бүр манайхтай харилцаатай хүүхдүүдэд [хүүхдэд] аюулгүй орчин бүрдүүлэхэд идэвх санаачилгатай ажиллана.
- Байгууллагаас хэрэгжүүлэх буй бүхий л хөтөлбөр, үйл ажиллагаа, хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрүүдэд хүүхдэд учирч болох эрсдэлүүдийг урьдчилан үнэлэх, тэдгээрийг арилгахын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах учиртай.
- ХИС-гийн төв, бүс, улс орны салбарууд хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар холбогдох бүхий л хүний ойлголтыг нэмэгдүүлэх, хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлж, түүний дагуу ажиллана.

Дээр дурдсан арга замуудаар ХИС нь байгууллагаа хүүхдэд аюулгүй болгож, хүүхдийн эрх, өөрсдийн зорилго тэмүүлээ хүндэтгэж байгаа хэрэг юм гэж ХИС-гийн Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлогод бичсэн байдаг (ХИС, 2017, хууд.2). Түүнээс гадна ХИС-гийн хөтөлбөр, төсөл дээр ажиллах ажилтан албан хаагчид, сайн дурын ажилтнууд, хамтран ажилладаг түншлэгч байгууллага, зөвлөхүүдээс энэ бодлогын хэрэгжилттэй холбоотой гомдол, саналыг хүлээн ямар хэлбэрээр хүлээн авах, асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай тодорхой шат дараалалтай зохицуулалт бүхий зааврыг ХИС-гийн ажилтан албан хаагч болон хамтран ажиллах түншлэгч байгууллага, зөвлөхүүдэд түгээж бодлогын хэрэгжилтийг хангаж ажилладаг.



Мэдлэг шалгах асуултууд

1. Хүүхэд хамгааллын бодлого гэж юуг хэлэх вэ?
2. Хүүхэд хамгааллын бодлогод зайлшгүй тусгах ямар бүрэлдэхүүн хэсгүүд байдаг вэ?
3. Хүүхэд хамгааллын бодлого, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах бодлого хоёрын ялгаатай талуудыг нэрлэнэ үү
4. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд сургалт сурталчилгаа ямар үүрэгтэй вэ?
5. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд байгууллагын өөрийн үнэлгээ хэр ач холбогдолтой вэ?
6. Байгууллагын өөрийн үнэлгээг хэрхэн хийж болох вэ?

НОМ ЗҮЙ

Гадаад хэл дээрх эх сурвалж

- AVI. (nd). AVI Guide to Child Protection Policy Development. Australian Volunteers for International Development.
- Calder, J., & SCUK. (2019). Strengthening child protection system. not yet published. Retrieved from Save the Children: <https://savethechildren.mn/mn/post/1025>
- Safe. (2022). What is the difference between child protection and child safeguarding? Retrieved from Safeguarding associates for excellence: <https://www.safe-ltd.com/what-is-the-difference-between-child-protection-and-child-safeguarding/>
- Save the Children. (2003). Child protection policy. Retrieved from Child Rights Resource Centre: <https://www.savethechildren.org/content/dam/usa/reports/events/child-safeguarding-policy-2020.pdf>
- Save the Children. (n.d.). Save the Children's Child Safeguarding policy. Retrieved from Save the Children: https://www.savethechildren.net/sites/www.savethechildren.net/files/SCI_HR_POL_Child%20Safeguarding%20External%20Policy_EN.docx.pdf
- SC. (2007). Save the Children definition of Child Protection. Retrieved from Child Rights Resource Centre: <https://resourcecentre.savethechildren.net/document/save-childrens-definition-child-protection/>
- SCUK. (2010). National child protection system. not published.
- UNICEF. (2012). Child protection in Educational Settings: Findings from six countries in East Asia and the Pacific. Bangkok: UNICEF East Asia and Pacific Regional Office.
- WHO. (2016). Inspire: Seven strategies for ending violence against children. Geneva: WHO.
- WHO. (2020, June 8). Violence against children. Retrieved from WHO: <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/violence-against-children>

Монгол хэл дээрх эх сурвалж

- Батхишиг, А. (2011). Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны хэсэг болох нь. In Батхишиг, А, Энхтуяа, С, бусад,
- Батхишиг, А. (2019). ЕБС-ийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж. БСШУЯ.
- Батхишиг, А. (2019). Нийгмийн ажил: Хамгаалах хүчин зүйлс. УБ: Сэлэнгэ Пресс, ХХК
- Батхишиг, А. (2021). Хүүхэд хамгааллын тогтолцоо сулаас хүүхэд хүчирхийлэлд өртсөөр байна. УБ: Өнөөдөр сонин.
- Батхишиг, А. (2022). Хүүхдийн эсрэг хүчирхийлэл. In Батхишиг, А, бусад, Нийгмийн асуудлууд. УБ: Сэлэнгэ пресс ХХК. Хэвлэх үйлдвэр (Хэвлэгдэх шатанд).
- Батхишиг, А. (2022). Хүүхэд хамгааллын үйлчилгээ, Хоёр дахь хэвлэл, УБ: Сэлэнгэ Пресс ХХК. (Хэвлэгдэх шатанд).
- ГБХЗХГ. (2021). Мэдээ: Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг. Retrieved from ГБХЗХГ: <http://fcy.gov.mn/news/301>
- ДЭМБ. (2018). Inspire Гарын авлага: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх долоон стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээ. УБ: «Би Си Ай» ХХК.
- Мөнхсайхан, О. (2015, 1 25). Хүний эрхэм чанар. Retrieved from Trend.mn: <https://www.trends.mn/n/945>
- Наранцогт, Т. (2019). Хүүхдийн эрх болон хүүхэд хамгааллын эрх зүйн асуудал. In Гэр бүл, хүүхэд, залуучуудын хүний нөөцийг чадавхжуулах сургалтын гарын авлага (pp. 13-33). УБ.
- НҮБ. (1946). Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/1271>
- НҮБ. (1989). Хүүхдийн эрхийн тухай конвенц. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/1271>

- НҮБ. (1989). Хүүхдийн эрхийн тухай конвенц. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/1276>
- НҮБ. (1990). Монгол Улсын олон улсын гэрээ: Хүүхдийн эрхийн тухай конвенц. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/1276>
- НҮБ. (2021). Нэмэлт протокол: Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол. Retrieved from ГХЯ: <https://mfa.gov.mn/wp-content/uploads/2021/01/10.-ХҮҮХДИЙГ-ХУДАЛДАХ-ХҮҮХДИЙН-БИЕИЙГ-ҮНЭЛЭХ-ХҮҮХДИЙГ.cleaned.pdf>
- Оюунболд, Г, Намуун, П (2021). Зөрчлийн хэрэг. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нарт зориулсан гарын авлага. УБ: Ганбилэг Принт, ХХК; НГХБХЗХ.
- Оюунчимэг, Т, Болдбаатар, Ж, Эрдэнэбаяр, М, Нямсүрэн, Ч, Мөнхдорж, Б, бусад. (2019). Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: Шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс судалгааны тайлан. УБ: Мөнхийн үсэг.
- Түмэннаст, Г, Бүрэнжаргал, Т, Болдмаа, Н, Батбаатар, М, Одгэрэл, Ц, Оюунцэцэг, Д, Түмэндэлгэр, С (2018). Хамтарсан багийн өнөөгийн байдал, ололт, амжилт, тулгамдаж буй асуудлууд: «Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь» төслийн эцсийн судалгаа. УБ: ХИС.
- УИХ. (2016 а). Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль. Retrieved from Эрх зүйн мэдээллийн систем: <https://legalinfo.mn/mn/detail/11710>
- УИХ. (2016 б). Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль. Retrieved from Эрх зүйн мэдээллийн систем: <https://legalinfo.mn/mn/detail/11709>
- УИХ. (2017). Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/12696>
- ҮСХ. (2018). Хүчирхийллийн нүцгэн үнэн: Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017. УБ: ҮСХ.
хамгааллын удирдлага (pp. 7-29). УБ: ХИС.
- ХИС. (2007). Хүүхдийн эрхэд тулгуурласан арга зүй: Гарын авлага
- ХИС. (2009). Хүүхдийн эрхэд суурилсан хандлага. УБ: ХИС.
- ХИС. (2017). Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого. Retrieved from Хүүхдийг Ивээх Сан: https://www.savethechildren.mn/uploads/publication/201805/Хүүхдийн_аюулгүй_байдлыг_хангах_бодлого.pdf
https://www.savethechildren.mn/uploads/publication/201805/Хүүхдийн_аюулгүй_байдлыг_хангах_бодлого.pdf
- ХИС. (2022). Сурагчид ардчиллын үнэт зүйлсийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлж байна.
- ХНХЯ, ХЗДХЯ. (2022). Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390322996571>
- ХНХЯ. (2021). Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389973164651&showType=1>
- ХТҮЗ. (2018). Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тогтоол. Retrieved from ХНХЯ: <https://mlsp.gov.mn/content/detail/1769>
- Хүүхдийн ивээх сангийн олон улсын эвсэл, орч. УБ: ХИС
- ХЭҮК, НТБҮТ. (2020). Эрх зүйн боловсрол: Хүний эрхэд суурилсан хандлага, видео хичээл. Retrieved from You Tube: <https://www.youtube.com/watch?v=O3BAIbu3KfU>
- ХЭҮК. (2016). Хүний эрхэд суурилсан хандлага. Retrieved from asm.mn: <https://asmhub.mn/uploads/files/erkhed-suuirilsan-khandlaga.pdf>
- Цолмон, Э. (2019). Хүүхдийн эрхийн зөрчил гарахад хэнд, хаана, хандах вэ? УБ: ХИС.
- Энхжаргал, Д. (n.d.). In Д.Энхжаргал, ГБХ-тэй тэмцэх үүрэг хүлээгчдэд зориулсан сургалтын цөм хөтөлбөр. УБ: ХЭҮТ.



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361
✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN
📺 HairaarUlgerley